

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр, Лхагва гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-43

- 1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/*

4-5
- 2. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /УИХ-ын гишүүн Б.Энхбаяр нарын 3 гишүүн 2022.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/*

5-26
- 3. Хүнс, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын цаг үеийн нөхцөл байдлын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох*

26-43

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
04 дүгээр сарын 05-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл***

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Саранчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 35 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Ж.Батжаргал, Ц.Идэрбат, Н.Наранбаатар.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун үг хэлэв.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал байлцав.

Байнгын хорооны дарга Б.Саранчимэг тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Саранчимэг: “Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Г.Дамдинням нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 10 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 10 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /УИХ-ын гишүүн Б.Энхбаяр нарын 3 гишүүн 2022.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан “Азтай савар” ТББ-ын тэргүүн Ц.Зориглон, мөн ТББ-ын зохицуулагч Э.Бүжинлхам, удирдах зөвлөлийн гишүүн З.Золзаяа, Ц.Болормаа, Д.Оюун-Эрдэнэ, хуульч Б.Алтаншагай, “Өмгөөллийн легал гайд” ХХК-ийн хуульч Э.Анударь, мөн ХХК-ийн эрх зүйч Н.Баясгалан, “Эм-Ди-Эс Хаан Лекс” хуулийн фирмийн хуульч М.Ариунзул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав

Хууль санаачлагчийн илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Т.Аубакир, Г.Дамдинням, Т.Энхтүвшин, Г.Мөнхцэцэг, Ц.Туваан, Б.Саранчимэг нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, “Азтай савар” ТББ-ын тэргүүн Ц.Зориглон, мөн ТББ-ын зохицуулагч Э.Бүжинлхам, удирдах зөвлөлийн гишүүн З.Золзаяа, Ц.Болормаа, Д.Оюун-Эрдэнэ, хуульч Б.Алтаншагай, “Өмгөөллийн легал гайд” ХХК-ийн хуульч Э.Анударь, мөн ХХК-ийн эрх зүйч Н.Баясгалан, “Эм-Ди-Эс Хаан Лекс” хуулийн фирмийн хуульч М.Ариунзул нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням үг хэлэв.

Б.Саранчимэг: Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Хүнс, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын цаг үеийн нөхцөл байдлын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Санчирдорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Хүнс, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын цаг үеийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Г.Мөнхцэцэг, Г.Тэмүүлэн, Ц.Туваан, Б.Саранчимэг нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд үг хэлээгүй болно.

Хүнс, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын цаг үеийн нөхцөл байдлын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 13 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 38 минут үргэлжилж, 19 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 79.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 13 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.САРАНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр,
Лхагва гараг

Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим 10 цаг 35 минут.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Саранчимэг: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Тэгээд Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 52.6 хувьтай болсон тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11-ийн 6-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог, нэрээр танилцуулна.

Цогт-Очирын Анандбазар Булган аймаг гадаадад томилолттой, Тилеуханы Аубакир ирсэн байна. Жигжидийн Батжаргал орон нутагт томилолттой. Буланы Бейсен Баян-Өлгий аймаг ирсэн байна. Хаянгаагийн Болорчулуун Дорнод ирсэн байна. Гочоогийн Ганболд Өвөрхангай аймаг, чөлөөтэй байна. Наянтайн Ганибал Сүхбаатар ирж байна гэж сая ярьсан. Гонгорын Дамдинням Дархан-Уул аймаг ирсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат Хэнтий аймаг орон нутагт томилолттой. Гомпилдоогийн Мөнхцэцэг Дундговь, Говьсүмбэр ирсэн байна. Нанзадын Наранбаатар Өмнөговь өвчтэй байна. Дамдинсүрэнгийн Өнөрболор Сэлэнгэ аймаг ирсэн байна. Батсүхийн Саранчимэг Баянзүрх ирсэн байна. Ганзоригийн Тэмүүлэн Архангай аймаг ирсэн байна. Цэвэгдоржийн Туваан Төв аймаг ирсэн байна. Одонгийн

Цогтгэрэл ирээгүй байна. Цэдэндамбын Цэрэнпунцаг ирж байна гэсэн. Төмөртоогоогийн Энхтүвшин Дорноговь аймаг ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгт, Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа. Цаглавар батлах.

Хоёрт, Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр, Хууль зүйн сайд Нямбаатар, Ж.Сүхбаатар нараас 2022 оны 9 сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн хууль байна.

Гуравт, Хүнс, хөдөө аж ахуйн газар тариалангийн салбарын цаг үеийн нөхцөл байдлын талаар Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох байгаа.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Болорчулуун сайд.

Х.Болорчулуун: Байнгын хорооны хурал энэ 3 дахь өдөр үдээс өмнө гэхээр яг Засгийн газрын хурал давхцаад байна. Манай хөдөө аж ахуйтай холбоотой 2 ч асуудал орох гээд байгаа юм. Одоо яг хүлээгдэж байна. Тэгэхээр энэ тайлан биш мэдээлэл юм чинь энэ мэдээллийг Төрийн нарийн, бодлогын дарга энэ тэрээр мэдээлэл тавиулчих уу? Айн?

Б.Саранчимэг: Мэдээлэл юм чинь тухайн үед нь яриад явчихъя. Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байхгүй тул хэлэлцэх асуудлаа баталлаа.

Нэгдүгээр асуудал. Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах

тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын дарга 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 56 дугаар захирамжийг баталсан байгаа. Тэгэхээр энэ Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд энэ дарааллыг үндэслэн хэлэлцэх асуудлын цаглаврыг Байнгын хороо баталж мөрдүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа учраас төсөлтэй холбогдуулаад та бүхэн саналтай гишүүн байна уу? Алга байна.

Санал байхгүй байгаа учраас Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг батлахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүй болголоо. Энэ техникийн асуудлаас болоод.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг батлахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Протоколоор Дамдинням гишүүнийг дэмжсэнээр оруулаарай. Бейсен гишүүн бас татгалзсанаар орчихсон байна. Дэмжсэнээр оруулаарай. Дараагийн асуудлыг хэлэлцье.

10.46 цаг

Хоёрдугаар асуудал. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд байгаа.

Хууль санаачлагчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Энхбаяр танилцуулна.

Б.Энхбаяр: Байнгын хорооны эрхэм дарга, гишүүдийн өглөөний амгаланг айлтгая. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төслийг 2022 оны 9 сарын 26-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн миний бие Нямбаатар, Ж.Сүхбаатар нарын хамт Улсын Их Хуралд өргөн барьсан байгаа.

Энэ хуулийг санаачлах болсон бас шалтгаан, үндэслэл, түүхийг бас та бүхэнд товч танилцуулъя.

Тэгэхээр энэ хуульч гишүүд яагаад гэнэт Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төслийг санаачлах болов гэж. 2021 оны намар надтай “Азтай савар” төрийн бус байгууллагын залуучууд, энэ ажлын хэсгийн гишүүд уулзах хүсэлт тавьсан. Тэгээд уулзаж үзсэн ийм Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл Монгол Улсад шаардлагатай, зайлиггүй ийм зохицуулах харилцаа бий болчхоод байгаа юм.

Тэгээд энэ дээр бас хууль санаачлагчаар бас оролцож, бидний гүүр болж өгөөч гэсэн ийм хүсэлтийг тавьсан. Тэгээд миний хувьд их тийм ойлголт муутай, өөрөө бас амьтан тэжээдэггүй. Тэгээд сайн ярилцаж, холбогдох судалгаа юмнуудыг авч үзэхэд энэ ганицхан амьтны тухай хууль биш юм байна. Энэ ерөөсөө хүний асуудал юм байна. Хүний эрхийн асуудал юм байна. Их олон нийгмийн суурь шалтгаантай холбоотой асуудал юм байна гэдэг ийм дүгнэлтэд хүрсэн.

Өнөөдөр манай улсад 320000 эзэнгүй муур, нохой Улаанбаатар хотод

байж байна. Ер нь сүүлийн 100 гаруй жилийн турш энэ эзэнгүй нохой, муурайг яаж устгаж байна вэ гэхээр буудаж алах аргаар устгаж байгаа юм. Улаанбаатар хотын хувьд гэхэд жилдээ 100000 нохойг буудаж устгах төлөвлөгөө гаргаж ажилладаг 1 жилд. Үүндээ 1.8 тэрбум төгрөг төсөвлөдөг татвар төлөгчдийн мөнгөнөөс. Ингээд хүнд, аюултай аргаар энийг буудаж цөөлөхийг эрмэлздэг.

Гэтэл энэ муур, нохой гэдэг амьтан маань яаж үрждэг юм бэ гээд аваад үзэхээр хос 2 нохой 1 жилд 16, 2 жилд 128, 3 жилд 512, 4 жилд 12000, 6 жилд 67000 болж үрждэг.

Хос 2 муур 1 жилд 24, 2 жилд 376, 3 жилд 11000, 4 жилд 37000, 6 жилд 1 сая болж үрждэг. Өөрөөр хэлбэл энэ үржлийн хурд нь одоо тэр устгаж яах ямар ч тийм боломж нөхцөлийг олгодоггүй. Энэ нь цаашаа ямар асуудлуудыг бий болгоод байгаа юм бэ гэж. Нэгдүгээрт энэ байгаль орчны маш хурц асуудал болж хувирсан. Зонозын өвчин судлалын төвөөс хийсэн судалгаагаар халдварт өвчний үндсэн шалтгааны нэгдүгээрт хөрсний бохирдол.

Хоёрдугаарт эзэнгүй муур, нохойны одоо энэ устгал хөрсөнд булагдаж байгаа энэ асуудал гол халдварт өвчний шалтгаан нөхцөл болж байна гэдэг ийм дүгнэлтийг гарсан байгаа.

Нохойноос шинжилгээ авч үзэхэд 300 гаруй зоонозын халдварт өвчнийг тээдэг гэсэн ийм их аюултай дүгнэлт гарч ирж байгаа юм. Ингээд хүмүүс ер нь энэ тарилга юм хэр урьдчилан сэргийлэх чиглэл дээр ямар байдалтай хэр ажилладаг юм бэ гээд аваад үзэхээр энэ нь өөрөө туйлын хангалтгүй. Ийм дүнтэй. Өөрөөр хэлбэл тэр нөгөө хязгааргүй саяын хэлсэн тэр үржих тэр хязгаарлалт юмнуудыг хийдэггүй ийм байдалтай. Үүнээсээ болоод хэмжээ хязгааргүй өсдөг. Ингээд өнөөдөр

Улаанбаатар хотын хувьд хаа сайгүй эзэнгүй тэнэмэл нохой, муур ингэж бий болсон.

Тэгээд энэ төрийн бус байгууллагын залуучууд 10 гаруй жилийн өмнө энэ асуудал дээр анхаарал хандуулж сайн дураараа эвлэлдэн нэгдэж, тэгээд энийг яаж шийдэх вэ гэдэг дээр 10 жилийн турш өөрсдөө ажиллаж ажиллажээ. Төрөл бүрээрээ ажиллаж байна. Тэр эзэнгүй нохдыг аварч байна, хамгаалж байна. Үржлийг нь тэр шинжлэх ухааных нь үндэстэйгээр хаах тэр ажлуудыг өөрсдийн тэр сайн дурын үндсэн дээр зохион байгуулж байна. Төр нь нөгөө талаараа татвар төлөгчдийн мөнгөөр энийг алж устгах, буудах аргаар үзэж байна. Тэгээд энэ бол үр дүнд хүрэхгүй гэдэг нь нэгэнт тодорхой болсон байна.

Дэлхийн улс орнууд 120 гаруй улсууд ийм гэрийн тэжээвэр амьтны хуультай болсон байна. Тэгэхээр энэний цаана энэ нийгмийн эрүүл мэндийн ийм шалтгаан нөхцөлүүдийн асуудал 1 дүгээр шалтгаан нөхцөл юм байн. Энэ бол одоо амьтны хууль гэхээс гадна хүний хууль, хүнээ бодсон хууль юм байна гэдэг нэг дэх дүгнэлт өгч байгаа юм.

Хоёр дахь дүгнэлт энэ амьтантай харгис хэрцгий аргаар ханддаг тэгээд энийг чинь буудаж устгадаг. Хүнд аюултай. Энд хүн өртвөл яах вэ, хүүхдүүд өртвөл яах вэ? Ийм их хурц асуудал бий болоод байна. Тэгээд дийлэхгүй. Тэгээд энэ буудаж устгасан муур, нохойгоо шатааж дийлэхгүй. Улаанбаатар хотод ганц шатаах зуухтай. Тэр шатаалтын үнэ өртөг гэдэг маш аюултай. Тэгээд нөгөө 70 давхар гэж ярьдаг хүний оршуулгын газраасаа илүү энэ нөгөө амьтнаа устгах хөрсний бохирдлын үндсэн шалтгаан болчихоод байгаа юм. Үндсэн шалтгаан.

Тийм учраас энийг бид нар араас нь ингэж буудаж алаад нэгдүгээрт харгис хэрцгий аргаар яваад бол дийлэхгүй юм байна. Ерөөсөө гол асуудал

бол урьдчилан сэргийлэх асуудал юм байна.

Сүүлийн үед хүмүүс амьтанд хайртай хүмүүсийн тоо нэмэгдэж байгаа. Ялангуяа нийслэл Улаанбаатар хотын хувьд одоо орон сууцдаа, хаашаа байшиндаа муур, нохой тэжээдэг иргэдийн тоо нэмэгдэж байгаа. Судалгаа авч үзэхэд орон сууцад амьдарч байгаа иргэдийн 10 гаруй хувь нь муур, нохойтой гэсэн дүн гарсан. Гэр хороололд энэ 50 хувьтай байгаа.

Тэгэхээр энэ үндсэндээ нэлээн олон иргэдийн амьтантай харьцдаг ийм харилцаа бол нэгэнт бий болчихжээ. Үүний цаана юу болж байна вэ гэхээр эргээд дахиад зөрчил бий болж байна. Амьтан тэжээдэг хүмүүс, амьтан тэжээдэггүй хүмүүс гэсэн ийм 2 янзын хүмүүс бий болоод. Нөгөө амьтнаа салхилуулах ёстой. Тэгэхээр нөгөө хүн гудамж талбай, гадаа байгаа цэцэрлэгт хүрээлэн ийм газруудад хошуувчгүй, бусдын аюултай байдлаар нохой юмаа салхилуулдаг. Нөгөө баас, нохойныхоо ялгадсыг цэвэрлэдэггүй, авч явдаггүй. Энэ нь өөрөө орчны бохирдлын бас 1 том шалтгаан болчихоод байгаа юм.

Тийм учраас энэ эздийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх ийм шаардлага байна. Тэр нохой юмаа салхилуулаад яаж байгаа бол тэр ялгадас юмыг нь цэвэрлэж авч явж байх үүрэгжүүлэх хэрэгтэй байна. Тэр хошуувчийг нь зүүлгээж заавал хийж авч байж олон нийтийн газар салхилуулж байх үүргийг үүрэгжүүлэх шаардлагатай байна. Хууль зүйн хувьд.

Тэгэхгүй болохоор энэ юу болж байна вэ гэхээр 2020 онд хийсэн судалгаагаар 3850 хүн нохойд хазуулсан байна. Үүний 40 хувь нь 15 хүртэлх насны хүүхдүүд хазуулсан байна. Хүүхдүүд. Энэ хүүхэд, хүмүүсийг, хазуулсан хүмүүсийг эмчлүүлэх зардалд 1 хүнд 120000 төгрөг бас гарсан гэдэг. Ийм судалгаа гарч ирж байна.

Тэгэхээр энэ өөрөө бас эрүүл мэндийн их том ийм шалтгаан болсон байна. Ингээд нөгөө 1 хазуулсан хүүхэд насаараа сэтгэл зүйн гэмтэлтэй болж үлдэж байна. Амьтнаас айх, бусдаас айх, цочих сэтгэл зүйн гэмтэлтэй болж байгаа. Ийм айдастай автаж байна. Тэгээд ийм олон, ийм шалтгаан болж байна.

Тийм учраас энэ орон сууцад энэ амьтныг тэжээх асуудал дээр ямар үүрэг хариуцлагатай байх вэ гэдэг ийм асуудал ярьж байна. Сая би тойргоороо уулзалт хийгээд ирсэн. Манайд жишигээр 15 дугаар хороонд Баянзүрх дүүрэгт ахмадууд ийм хүсэлт тавьж байна. Шөнө унтаж амарч чадахаа болилоо. Ерөөсөө орон сууцын газар эзэнгүй нохойд ерөөсөө тасралтгүй хуцалдаад, хүн шөнө орой амарч чадахаа болилоо. Гараад сүүдрэвчинд амраад, жоохон тоглоод суудаг байсан. Тэгж чадахгүй байна. Энэ чинь ерөөсөө эргэн тойрон эзэнгүй нохойгоор дүүрчихлээ. Айдастай болоод байна. Ийм асуудал ихээр тавигдаж байгаа юм.

Тийм учраас энэ нийгмийн шалтгаан байна, эрүүл мэндийн шалтгаан байна, байгаль орчны шалтгаан байна.

Хамгийн төгсгөлд нь би 1 зүйлийг хэлэхэд бид хүний эрхийн асуудлыг ярьж байгаа. Бид бол ардчилсан, хүмүүнлэг нийгмийг хөгжүүлэх ийм зорилт тавьсан. Хүн хүнээ хайрлах сэтгэл бол хүн хүнээ, хүн амьд амьтныг хайрлах энэ сэтгэлээс үүдэх ёстой. Бид амьтантай харгис хэрцгий ханддаг энэ үзэл хандлагыг бид таслан зогсоож, үр хүүхдүүдээ өвлүүлж болохгүй.

Амьтныг тамлаж байгаа, яргалж байгаа тэр бичлэгүүдийг үзсэн тэрийг амьдаар харсан хүүхэд мөн сэтгэл зүйн гэмтэлтэй болж өсөж байна. Тэнд яргалж юу хийж байгаа, тэр амьд амьтныг яргалж байгааг харсан.

Тийм учраас энэ бол өөрөө нөгөө талаараа хайрыг сурталчлах хууль, хайрыг түгээх хууль, бусдыг энэрэх, ойлгох, хайрлах тэр үзлийг түгээн дэлгэрүүлэх хууль юм гэж. Тэр утгаараа би “Азтай савар” байгууллагын энэ залуучуудын санаачилсан тэдний бүтэн сүүлийн 10 жилийн хугацаанд хийсэн энэ хөдөлмөр зүтгэл, сүүлийн 1 жилийн хугацаанд яг энэ хууль дээр гардаж ажилласан энэ зүйлийг Их Хурлын гишүүн Нямбаатар, Сүхбаатар бид 3 Улсын Их Хурлын танхимд оруулж ирж байгаа гүүр нь болж байгаа юм.

Яг жинхэнэ санаачлагч нь бол энэ иргэд өөрсдөө, залуучууд. Бид бол энэ дамжуулагч нар. Тэгээд D-parliament дээр хуулийн төсөл маань анх тавигдсан. Улсын Их Хурлын дарга бас энийг онцлоод байгаа. D-parliament дээр энэ хуулийн төсөл дээр хамгийн олон иргэд орж саналаа өгсөн. Нийтдээ 11800 иргэн энэ хуулийн төсөл өргөн баригдсанаас хойш орж үзсэн. 25800 иргэд лайк дарж дэмжсэн. 202 санал хүсэлт ирсэн ийм хуулийн төсөл байгаа.

Тийм учраас Улсын Их Хурал маань ард түмний төлөөллийн дээд байгууллагынхаа хувьд ард түмний төлөөлөл болсон энэ залуучуудын өөрсдийнх нь санаачилж хийсэн энэ хуулийн төслийг бас хэлэлцэх эсэхийг дэмжиж өгөхийг хүсье та бүхнээс.

Б.Саранчимэг: Энхбаяр гишүүнд баярлалаа. Тэгэхээр хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж ирсэн ажлын хэсгийг та бүхэнд танилцуулъя.

Зориглон “Азтай савар” төрийн бус байгууллагын тэргүүн, уран бүтээлч, Э.Бүжиглхам “Азтай савар” төрийн бус байгууллагын зохицуулагч, Эм Си Эс Интернэйшнл ХК-ийн ахлах мэргэжилтэн, Золзаяа “Азтай савар” төрийн бус байгууллагын Удирдах Зөвлөлийн гишүүн, “Эм-Ди-Эс Хаан Лекс” хуульч, Болормаа “Азтай савар” төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, Оюун-Эрдэнэ “Азтай

савар” төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, Хаан Банкны төслийн менежер, Алтаниагай “Азтай савар” төрийн бус байгууллагын хуульч, Ариунзул “Эм-Ди-Эс Хаан Лекс” хуулийн фирмийн хуульч, Анударь “Өмгөөллийн легал” ХК-ийн хуульч, Баясгалан “Өмгөөллийн легал гайд” ХХК-ийн эрх зүйч ирсэн байна.

Гишүүд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу? Нэрээ өгье. Туваан гишүүнээр тасаллаа. Бейсен гишүүн асуултаа асууя.

Б.Бейсен: Энэ гэрийн тэжээвэр амьтан тухай хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Тэгэхдээ бас учир дутагдалтай юм байна гэж харж байна. Зөвхөн муур, нохойгоор хязгаарлагдахгүй энэ усан гахай тэжээж байгаа ч улсууд байна, зараа тэжээж байгаа улсууд байна. Ганц нэг хөдөөгүүр тарвага, үнэг тэжээж байгаа улсууд байж байна, чоно тэжээж байгаа улсууд байж байна. Зарим амьтад тэжээж байгаа улсууд байна. Тэгэхээр чинь энийг дахиад 1 мал эмнэлгээр хариуцна гэхээр бас учир дутагдалтай юм шиг байна. Энэний хариуцах алба бий болох уу? Тусдаа гадаад оронд энэ гэрийн тэжээвэр амьтныг хариуцсан албатай, эмчтэй тийм юм байдаг.

Энэ дотор бас аюултай нохойн шүлсэнд галзуугийн микроб байдаг. Галзуугийн вакциныг нохойд хазуулсан 3000 хэдэн зуу хүн нохойд хазуулсан гээд ярьж байна. Нохойд хазуулсан тохиолдолд галзуугийн вакциныг 24 цагийн дотор тариулах ёстой. Дараа нь тэр шил энэ тэрийг нь, тарьсан тариур энэ тэрийг нь шатааж байгаад устгах ёстой. Тэгэхээр чинь энийг зөвхөн малын эмнэлэг энэ дээр хяналт тавихгүй байгаа юм. Эмнэлгийн нөхцөлд зүгээр тариад л эмнэлгийнхэн юуг нь устгаад аюулгүй болгоод, тарианы тэр тариур, шилийг нь устгаж байгаа юм. Энэ асуудал дээр ямар зохицуулалт байдаг болов? Энэ талаар асууя.

Б.Саранчимэг: 4 номерын микрофоныг өгье.

Э.Анударь: Байнгын хорооны дарга эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан “Азтай савар” төрийн бус байгууллагын гишүүн Анударь байна. Бейсен гишүүний асуусан асуултад хариулъя.

Тэгэхээр энэ гэрийн тэжээвэр амьтантай холбоотой эрх зүйн харилцаа өмнө нь Монгол улсад байгаагүй. Өмнө нь мал, гэрийн тэжээвэр амьтнаас бусад амьтныг хамгаалахтай холбоотой харилцааг Амьтны тухай хуулиар, мал, тэжээвэр амьтан, зэрлэг амьтнаас ашиг шимийг нь хүртэж аж ахуй эргэлтэд орж байгаа эдгээр амьтадтай холбоотой харилцааг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулиар зохицуулж ирсэн. Яг энэ хүнтэй ашиг шимийг нь ашиглахаас өөр бусад зорилгоор тэжээж байгаа гэрийн тэжээвэр амьтантай холбоотой харилцаа Монгол Улсад ямар нэгэн хууль тогтоомжоор зохицуулагдаагүй байсан учраас энэ хууль маань өөрөө анхдагч хуулийн төсөл болж гарч ирж байгаа.

Энэ хуулийн маань төслийн нэр өөрөө Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл 9 бүлэг, 52 зүйлтэйгээр боловсруулагдсан. Хуулийн төслийг ингээд бүтцийн хувьд аваад үзэх юм бол нохой, мууртай холбоотой яг энэ бүлэг зохицуулалтууд дийлэнх хэсгийг нь ингээд хамарч байгаа юм шиг харагдаж байгаа. Гэвч энэ маань өөрөө ерөөсөө бүх гэрийн тэжээвэр амьтан гэсэн тодорхойлолтод орж байгаа тэдгээр амьтадтай холбоотой хамгийн суурь харилцааг зохицуулж байгаа.

Тэгэхээр яг хамгийн нийгэмд одоо тулгараад байгаа эрүүл мэнд, нийтийн эрүүл мэнд, зоонозын халдварт өвчин зэрэг асуудалтай хамгийн их тулгамдаад байдаг 2 амьтан нь нохой муур. Тэр

амьтантай холбоотой яг тусдаа бүртгэл, үржүүлэхтэй холбоотой зохицуулалтыг дэлгэрэнгүй бүлэг болгож тусгасан. Харин гэрийн тэжээвэр амьтан тэжээж байгаа түүнийгээ хүчирхийллээс хамгаалуулах гэж байгаа эдгээр харилцаа бол энэ манай хуулийн үйлчлэх хүрээнд хамаарч байгаа гэж ойлгож болно.

Тэгэхээр ганц нохой, муур гэхгүй. Гэрийн тэжээвэр амьтан гэртээ тэжээж байгаа, асран хамгаалж байгаа бүх хүний нийтлэг эрх үүргийг тусгасан, хүчирхийллээс амьтдаа хамгаалах зохицуулалтуудыг оруулж өгсөн.

Харин яг энэ тусдаа энэ алба бий болох уу гэдэг асуултад хариулахад яг одоогийн байдлаар яг энэ манай яам, тамгын газар, агентлагуудаас, яг гэрийн тэжээвэр амьтантай холбоотой харилцааг хариуцсан хэсэг, алба, мэргэжилтэн гэх юм уу байхгүй байгаа.

Тэгэхээр энэ хуулийн төслөөр яг тусдаа алба бий болгох шаардлагагүйгээр бид нар одоо байгаа нөхцөл байдлынхаа хүрээнд хэрэгжүүлэх болох арга хэмжээнийхээ хүрээнд зохицуулалтуудаа хийж өгсөн.

Дээрээс нь гэх юм бол нохойд хазуулаад тарьж байгаа асуудал. Ингээд эмнэлэгт үзүүлж байгаа асуудал гэх юм бол угаасаа зах зээлийнхээ зарчмаар мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд өөрсдөө цаанаасаа байгуулагдана, үйлчилгээ нь сайжирна. Гэрийн тэжээвэр амьтантай холбоотой зүгээр л наад зах нь гэхэд бараа хэрэгсэл, хувцас хунар, эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой тэр зах зээлүүд, бизнесүүд өөрөө байгалийнхаа жаммаар урган гарч ирнэ гэж ойлгож болно. Баярлалаа.

Б.Саранчимэг: Бейсен гишүүн тодруулъя гэж байна.

Б.Бейсен: Энэ гэрийн тэжээвэр амьтны хоол тэжээлийн асуудлыг яаж шийдэх юм? Энэ хуульд орох юм уу

нэгдүгээрт? Яагаад гэвэл нохой чинь хаягдал хоол, малын цэг, янз бүрийн бохир юмаар холдож байгаа шүү дээ. Хүний ялгадас гэх мэт. Үүнийг яаж шийдэх вэ нэгдүгээрт?

Хоёрдугаарт галуу, тахиа, нугас тэжээж байгаа улсууд байж байна. Энэ шувуу энд орох уу энийг яаж шийдэх вэ?

1 номерын микрофоныг өгье. Өөрсдийгөө танилцуулаад, асуултад тодорхой хариулаад яваарай.

Б.Алтанишагай: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Хуульч, “Азтай савар” төрийн бус байгууллагын хуулийн зөвлөх Алтанишагай байна.

Тэгэхээр энэ хоол тэжээлтэй холбоотой асуудлыг болохоор энэ хуулийн тэр асран хамгаалагч, түр харагч нарын үүрэг дээр тусгаж өгсөн байгаа. Гэрийн тэжээвэр амьтдыг ямар хоолоор хооллох юм бэ гэх юм бол тэр биеийн онцлог, үйлдвэрийн онцлог, тухайн амьтны онцлогт зориулсан шим тэжээлтэй хоолоор хооллоно гэсэн байгаа. Тэгэхээр гэрийн тэжээвэр амьтдыг ерөнхийдөө бол тэр бохир хоол ч юм уу тиймэрхүү юмаар хооллож болохгүй. Энэ маань өөрөө тэр гэрийн тэжээвэр амьтдын эрүүл мэндийн асуудал, цаашилаад энэ нийгмийн, тэр гэрийн тэжээвэр амьтныг тэжээж байгаа хүмүүсийн эрүүл мэндийн асуудалтай учраас энэ асуудлыг болохоор хуульд үүрэг дээр нь нарийн тусгаж өгсөн байгаа.

Б.Саранчимэг: Аубакир гишүүн асуултаа асууя. Аубакир гишүүний микрофоныг өгье.

Т.Аубакир: Энэ хуулийг оруулж ирж байгаа залуучууддаа бас баярлалаа гэж хэлэх нь зөв. Энэ өмнө манай улсад байгаагүй зохицуулалт. Сүүлийн үед хүүхэд залуучууд, гэр бүл бол гэрийн тэжээвэр амьтныг олноор үржүүлдэг, асардаг ийм айл өрх их бий болсон л доо.

Түрүүн Энхбаяр гишүүн бас эхлэхдээ хэлж байна. Энэ золбин нохойны асуудал, энэ золбин ноход хүүхдүүдийг урдаг, айлгадаг. Ялангуяа гэр хороолол, захын хорооллууд дээр байсан. Одоо бол бүүр хотын төвөөр ч гэсэн үндсэндээ зэрлэг ноход их бий болсон. Энэ Богд ууланд ан амьтан барьж идэж байгаа гэх зэрэг маш олон сөрөг мэдээллүүд их явдаг болсон л доо.

Тийм учраас энэ дээр ийм зохицуулалт оруулж өгөх нь ялт ч байхгүй зөв. Одоо энэ цаг үед амьтныг хайрлах битгий хэл, хүнийг хайрлахаа больсон ийм цаг. Тийм учраас яах арга байхгүй энэ амьтантай зүй зохисгүй харьцах, тухайн амьтныг тарчлаан тамлан алах, хороох энэ чинь сошиал хөгжчихсэн энэ үед хүүхдүүд тэрнээс харж ингэж болдог юм байна гэж хүмүүжил авах зэргийг зохицуулахад энэ бол зөв хууль орж ирж байна гэж үзэж байна.

Тэгээд энэ дээр эдгээр зөрчил гаргасан иргэдийнхээ зөрчлийг Зөрчлийн хуультайгаа яаж уяж өгсөн бэ? Жишээлбэл хошуучгүй явж байгаад хүн ургах юм бол Зөрчлийн тухай хуулиар зохицуулах юм уу? Зүй зохисгүй хөнөөсөн бол ямар хуулийн зохицуулалтаар явах юм? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт энэ золбин нохдын байдаг юм уу? Одоо тухайн гэрийн тэжээвэр амьтнаа устгалд оруулах энэ процесс нь бас яг яаж явах юм?

Одоо золбин нохдыг устгахад үндсэндээ багийн дарга, хорооны даргад нь үүрэг өгөөд л сумыг нь тоолж өгөөд л буудуулаад байгаа бололтой байдаг юм.

Тийм учраас энэ устгалын асуудлыг яг одоо буудаж алахыг тарчлаад алж байна гэж үзэж байгаа юу Энхбаяр гишүүн ээ? Өөрөөр яаж хороож алсан байх вэ? Гоёор гэх юм уу, юу гэх юм. Энэ зохицуулалтуудаа яг яаж оруулж өгөх юм? Ийм 2 асуулт л байна. Зөрчил гаргасан тэр амьтны эздийг

Зөрчлийн хуультайгаа яаж уяж өгсөн юм? Зөрчил гаргах юм бол.

Хоёрдугаарт энэ устгалынхаа асуудлыг өөрөөр шинэ технологи хэрэглээд байдаг ч юм уу, устгах өөр ямар асуудал байгаа юм? Жишээлэх юм бол ялангуяа энэ хөдөө аймаг, сумууд дээр бол буудаж алхахаас өөр арга байхгүй. Тэр нь эргээд нөгөө хотын гудамжиндаа үндсэндээ буу үүрчихсэн нөхдүүд явж байдаг юм шүү дээ. Гэтэл сум алдах тохиолдол хүртэл гарч байсан. Урьд нь. Энэ 2 асуудлыг яг яаж зохицуулах вэ гэсэн асуулт. Энэ хуулийг үндсэндээ дэмжиж байгаа. Мааш зөв зохицуулалт. Залуучуудад бас баярлалаа гэж хэлье.

Б.Саранчимэг: Мааш тодорхой асуулт асуулаа 4 номерын микрофоныг өгье.

Н.Баясгалан: Сайн байцаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. “Өмгөөллийн легал гайд” фирмийн эрх зүйч Баясгалан байна.

Тэгэхээр асуулт асуусан эрхэм гишүүн Аубакир гишүүндээ мааш их баярлаа. Эхний асуултад хариулъя. Тэгэхээр Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төслөөр асран хамгаалагч болоод түр харгагч нь хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол холбогдох Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээхээр зааж өгсөн байгаа. Энэ нь өөрөө Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гээд энэ хуулийг дагалдан батлагдах энэ хуулийн төсөлд өөрөөр хэлбэл эрх зүйн хариуцлагын системийг оруулж өгсөн гэж хэлж болно.

Тухайлбал яг жишээлээд дурдах юм бол гэрийн тэжээвэр амьтан нохой эсвэл муурын бичил чип суулгаж бүртгүүлэх, үржил хаах мэс ажилбар хийлгээгүйгээс бусад үүргээ биелүүлээгүй бол хувь хүнийг 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хуулийн этгээдийг 1000 нэгжтэй тэнцэх

хэмжээний төгрөгөөр торгох гэх мэтчилэн хуулийн төсөл нь яг ардаасаа эрх зүйн хариуцлагаа дагуулаад явж байгаа ийм системийг оруулж өгч байгаа гэж хэлж болно.

Б.Саранчимэг: Нэмж 1 номерын микрофоноос хариулъя.

Д.Оюун-Эрдэнэ: Сайн байцаана уу? “Азтай савар” төрийн бус байгууллагын гишүүн, “Хаан” банканд төслийн менежер Оюун-Эрдэнэ байна.

Хоёр дахь асуулт буюу Аубакир гишүүний устгалтай холбоотой асуудлыг яаж шийдэх вэ гэдэг асуултад хариулъя.

Ер нь устгал гэдэг маань өөрөө эзэнгүй амьтны тоо толгой олироод, эзэнгүй амьтан байгаад байгаатай шууд холбоотой. Тэгэхээр яг урт хугацаандаа хуулийн төслийн зорилт нь эзэнгүй амьтангүй болох, эзэнгүй амьтан бий болохоос нь урьдчилан сэргийлэх арга хэмжээг ер нь цогцоор нь авч хэрэгжүүлэх шаардлагатай гэдэг рүү зорьж байгаа. Бусад улсын туршилагаас харахад ер нь дэлхийн 182 орны нэгдэн орсон газрын амьтны эрүүл мэндийн кодекс гэж байдаг. Энэ кодексоор улс орон бүрийг өөрсдийнхөө онцлог, нөхцөл байдалд тохирсон эзэнгүй амьтныхаа тоо толгойг бууруулах, устгах арга хэмжээг, менежментийг хэрэгжүүлэх ийм зөвлөмжүүд байдаг. Энэ зөвлөмжүүд дан ганц устгал гэхээсээ илүү асуудлын яг үндэс суурийг нь шийдэх, эздийг хариуцлагатай болгох, амьтдаа бүртгэж тоолох, үржлийг нь хязгаарлах. Тэгээд үүнээс гадна үнэхээр нөхцөл байдал шаардсан тохио болдолд тодорхой зөвшөөрөгдсөн амьтандаа халгүй, тарчлаахгүй аргаар устгахыг зөвшөөрч зөвлөдөг.

Манай улсын хувьд бол мэдээж яг энэ хууль батлагдаад шууд эзэнгүй амьтангүй болохгүй. Шилжилтийн буюу хууль хэрэгжиж эхлээд тодорхой үр дүн хүрэх хугацаанд эзэнгүй 200, 300

мянгаараа гудамжинд бий болчихсон байгаа амьтдыг устгахаас өөр аргагүй гэдгийг хуулийн төслийн багийн зүгээс хүлээн зөвшөөрч байгаа.

Тэгэхээр яг дагалдах хуулийн төсөлдөө бид нар 5 жилийн хугацаанд буудаж устгах арга хэрэглэгдэнэ гэдгийг хүлээн зөвшөөрч тусгасан байгаа.

Үүнээс цааш буюу яг урт хугацаандаа бид нар устгах амьтангүй болохын төлөө ер нь зорих нь илүү чухал гэж харж байгаа. Баярлалаа.

Б.Саранчимэг: Баярлалаа.
Дамдинням гишүүн асуултаа асууя.

Г.Дамдинням: Мал, амьтны эрх зүйн байдлын тухай хууль их л өргөн дэмжлэгтэй орж ирээд байгаа юм. Тэгээд нийгмийн хэрэгцээ шаардлага бол их олон. Өндөр хөгжилтэй орнууд амьтны эрхийг хамгаалдаг байгууллага их хүчтэй хуультай орнууд хүнтэй ижил гэж үзнэ эрхийг нь. Эмчилгээний зориулалтаар ч гэсэн амьтныг заавал байлгах ёстой болдог ийм нөхцөл байдал байгаа. Янз бүрийн сэтгэл зүйн асуудалтай эсвэл ганцаардсан ийм эмчилгээний зориулалттайгаар ч хүртэл амьтныг цуг байлгах тухай асуудал ярина.

Эсвэл Анимал Крийлти гээд амьтныг тамлаж, алж зовоож байгаа тухай асуудал яригдана. Олон нийтийн газар бусдад хохирол үзүүлэх ийм нөхцөл байдал түрүүн Энхбаяр гишүүний танилцуулга дээр нэлээн явлаа.

Мөн бас энэ тусгай хүчний байгууллагуудад байдаг нохойнууд байна. Харуул хамгаалалттай холбоотой нохойнууд байна гээд. Тэгээд ер нь маш олон зохицуулах шаардлагатай үндэслэл бол байгаа юм. Тэгээд надад 4 асуулт байна.

Нэгдүгээрт, хууль хэрэгжүүлэхэд шаардагдах эдийн засгийн тооцоолол ер нь яаж гарсан юм. Ямар хэмжээний

төсвийн ачаалал өгөх юм? Одоо байгаагаасаа ихдэж байна уу, багадаж байна уу гэдэг асуулт байна.

Хоёрдугаарт хууль хэрэгжихтэй холбогдуулаад дагалдах ямар хуулиудад өөрчлөлт орох вэ? Жишээ нь нийтээр амьдардаг нийтийн байр, орон сууцын байр гэсэн үг. Англиар бол “apartment”. Ийм барилгуудад амьтантай амьдаръя. Магадгүй амьдрал баян. Морь тэжээж болно шүү дээ гэртээ. Байдаг шүү дээ. Хүмүүс байдаг байхгүй юу. Нохой ч байгаа л байх мэдээж. Тэгэхээр энэ стандартуудад ер нь ямар өөрчлөлт оруулдаг юм бэ? Яг ийм асуудлууд баруунд гардаг байхгүй юу. Гэртээ бар тэжээсэн хүн ч байгаад байдаг юм. Тэгээд энэ асуудлууд дээр ер нь ямар зохицуулалт хийгээд байгаа юм? Энхийг бас ярих ёстой асуудал байхгүй юу. Тэгээд барилгын стандарт норм дүрэмд яаж өөрчлөлт оруулах юм? Дуу чимээг нь яаж хаах юм? Дуу чимээг нь хаах тухай стандарт орох юм уу, үгүй юм уу? Энэ хуулийг дагаад. Бүрэн боловсруулалтынх нь хувьд л ярьж байна шүү.

Гуравдугаарт олон нийтийн газар хүний амьдралын орчинд үзүүлж байгаа нөлөөллийн тухай яриад байна. Жишээ нь гэхэд хэн нэгний гэрийн үүдэн дээр нохойгоо байнга авчирч шээлгээд байдаг байхгүй юу хүмүүс. Тэгээд СӨХ-ын фейсбүүк дээр баахан гомдол. Тэгээд тэнд нь ямар зохицуулалт байхгүй. Тэгэхээр нөгөө олон нийтийн амьдардаг хэсэг буюу энэ ландшафт буюу гадна талын тохижилтын хэсэгт нохой бие засуулах газар, эсвэл бусад амьтныг салхилуулах газар гэж ийм стандартын өөрчлөлтүүд орох уу? Энэ хуулиараа зохицуулж байгаа юу?

Дөрөвдүгээрт бас 1 асуудал гарна. Би сургууль соёлд ингээд гадна сураад л явж байсан. Энэ тэжээмэл хонь, ямаа, үхэр, адуу гээд өөрөөр хэлбэл манай уламжлалт амьдралын хэв маягтай ойрхон амьтан хүмүүс тэжээж эхэлдэг. Тэрийг бол жишээ нь гэхэд тэжээмэл 1 хоньтой байгаа нөхөр жишээ нь гадна

чинь хонь худалдаж аваад гаргаж иднэ гэхээр нэлээн асуудал болж байж бас гаргадаг байхгүй юу. Тэгэхээр энэ хууль яаж энэ манай уламжлалт амьдралын хэв маягт нөлөөлөх юм? Энэ зохицуулалт бас байдаг шүү дээ заавал. Жишээ нь гэхэд юу гэдэг юм хонь аваад тийм торгуулсан тохиолдлууд байдаг байхгүй юу. Хонь худалдаж аваад нөгөөдхөө гаргаад идчихсэн чинь айлын тэжээмэл хонь гаргаад идчихсэн байна гээд ял шийтгэл авах хэмжээнд хүрч байсан асуудлууд гардаг байхгүй юу.

Нэгэнт бид нар ийм шинэ үеийн нийгэмд амьдрах гэж байгаа, шинэ үеийн зохицуулалт шаардаж байгаа энэ хууль хийж байгаа бол үүнийгээ яаж зохицуулж байгаа юм бэ? Ийм 4 асуулт байна.

Б.Саранчимэг: 1 номерын микрофоныг өгье.

М.Ариунзул: Дамдинням гишүүний асуултад хариулъя.

Өмгөөллийн “Эм-Ди-Эс Хаан Лекс” хуулийн фирмийн хуульч өмгөөлөгч “Азтай савар” төрийн бус байгууллагын гишүүн байна. Ариунзул байна. 4 асуултын эхний 2 буюу эдийн засгийн тооцоололтой холбоотой. Мөн хоёрт нь дагалдах өөрчлөлтийн хуулийн төсөлтэй холбоотой асуултад хариулъя.

Эдийн засгийн тооцооллыг бид нар болохоор Хууль тогтоомжийн тухай хуулийн аргачлалынхаа дагуу зардлын тооцоолол гаргаж үзсэн. Төрийн байгууллагад иргэн, хуулийн этгээдээс гадна төрийн байгууллагад ямар зардал гарах вэ, ямар чиг үүрэг нэмэгдэж байгаа вэ гэдгийг цаг хугацаа, минут, ажлын тооцоолол, хүний нөөцийн бүрэлдэхүүнээр нь авч үзсэн байгаа. Тэрхүү тооцоогоос харах юм бол бүх бүх чиг үүрэг дээр алба, түрүүний өмнөх хариултад хэлсэн алба болон хүний нөөцийн чиг үүргийн нэмэгдэх дарамт байхгүй байна гэж харсан.

Нэмэгдэхдээ харин ажлын хэсэг дээр нэмэгдэх дарамт нь 1 буюу 2. 3 гээд хүнээр нэмэгдэх гэдэг агуулга биш 0.4 хувиар ачаалал нэмэгдэх юм байна гэдэг тооцоолол гаргасан. 0.4 хувиар ачаалал нэмэгдсэнээрээ юу харагдаж байна вэ гэхээр тэр 4 хувьд тооцогдох тухайн хүний цалин хөлс, цалин хөлс зэрэг зардлын тооцоо гарах юм байна. Тэрийг бид нар ойролцоогоор нөгөө ТЗБ-аар ингээд тооцож үзэх юм бол ойролцоогоор төсөвт 26132703 төгрөгийн зардал гарах магадлалтай байна гэж тооцоолол гаргасан байгаа.

Дараагийн асуудал нь дагалдах хуулийн өөрчлөлтүүд гэж байгаа. Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль хуулийн төслийн чиг үүрэг болон эрх үүрэгтэйгээ холбогдоод дагалдах хуулийн төслүүд байгаа. Тухайлбал сая гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагч эрх үүргээ зөрчвөл Зөрчлийн тухай хуульд мөн эрх үүрэг зөрчсөнтэй холбоотой хариуцлагын заалтууд орж байгаа.

Мөн дээрээс нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль дээр чиг үүрэгтэй нь Мал амьтны эрүүл мэндийн газартай холбоотой чиг үүрэгтэй холбоотой заалтууд орж байгаа. Тэгэхээр дагалдах хуулийн төслүүдийг ерөнхийдөө өөрчлөөд явсан байгаа.

Б.Алтаншагай: Дамдинням гишүүний 3. 4 дэх асуултад хариулъя. Энэ олон нийтийн газрыг ялгадсаараа бохирдуулах асуудал, бусдын тэр эрх нь зөрчигдөж байгаа асуудлыг бас мөн адил үүргээр нь үүрэгжүүлж эзэд, тэр гэрийн тэжээвэр амьтны эздийг үүрэгжүүлснээрээ зохицуулж өгч байгаа. Ямар байдлаар зохицуулж өгч байгаа вэ гэх юм бол энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.5-д олон нийтийн газар, авто зам, гудамж талбай, орон сууцын орчны газарт цахилгаан болон явган шат, орц хонгилыг нохой, муурын ялгадсаар бохирдуулахгүй байх, бохирдуулсан тохиолдолд орчныг цэвэрлэж, ялгадсыг зориулалтын хогийн сав болон цэгт хаях

гэдэг байдлаар ерөнхийдөө үүрэгжүүлээд зохицуулж байгаа.

Үүнээс гадна тэр хүүхдүүдийн тоглоомын талбай, цэцэрлэгийн талбайд болохоор гэрийн тэжээвэр амьтныг салхилуулахгүй байдлаар мөн адил үүрэгт нь тусгаж өгсөн байгаа.

Тэр тэжээвэр хоньтой холбоотой асуудал гэх юм бол ерөнхийдөө таван хошуу мал гэдэг байдлаар орж ирнэ. Тийм байдлаар орж ирэх байгаа.

Б.Саранчимэг: Нэмээд Дамдинням гишүүн тодруулъя.

Г.Дамдинням: Энхбаяр гишүүн хариулсан нь дээр байх. Би тодруулаад дахиад асууя. Сая хэд маань зөвхөн нөгөө захиргааны зардалтай холбоотой төсвийн ачааллыг л хэлчих шиг боллоо. Тэр нийгэм эдийн засгийн нөлөөлөл гээд нэлээн том тооцоолол гарах ёстой байх. Мэдээж энэ гишүүд дэмжиж байх шиг байна. Тооцооллоо нэгдүгээрт нарийвчлах ёстой байх. Өргөн хэмжээнд харуулж ярих хэрэгтэй.

Хоёрдугаарт би та нараас асуусан юм бол энэ хууль гарснаар барилгын олон нийтийн амьдрах хэсгүүдэд ямар стандартын өөрчлөлтүүд гарах үүргийг ногдуулж байгаа юм? Хувь хүн ганцаараа энийг үүрээд байх зохицуулалт биш байхгүй юу. Оролцогч 1 л талд өгч байгаа үүрэг. Барилгын хотхон төлөвлөхөд хаана нь нохой, муурынхаа, зөвхөн нохой, муур гэж ерөөсөө хязгаарлаж болохгүй байхгүй юу даа. Зөвхөн хонь ч гэж хязгаарлаж болохгүй. Энэ чинь амьтны л асуудал байхгүй юу. Тэгэхээр энийг яаж тодруулаад байгаа юм бэ, яаж зохицуулаад байгаа юм бэ? Би хуулийг чинь дэмжихгүйдээ биш, зөв болгоод өргөн хүрээнд хамруулаад зохицуулчихыг л хичээгээд байгаа юм.

Б.Саранчимэг: Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Энэ гэрийн тэжээвэр амьтны холбоотой үүсэж байгаа харилцааг ер нь улс орны хөгжиж байгаа байдлын түвшинээрээ энэ түвшин нь харилцан адилгүй юм байна лээ. Манай Дамдинням гишүүн нэлээн “high”-өндөр level-ийн тийм бас өндөр хөгжилтэй оронд амьдарч туршилага судалж байж сууж байж яг тэр нөгөө энэ амьтанд хандах түвшиний нэлээн өндөр зэрэглэлийн хуулиас иүүд асууж байна. Энэ судалгааг хийж үзэхэд амьтныг хүний нэгэн адил амьтны эрхийн асуудал ярьж байгаа улсууд байна. Бүүр хүний эрх биш, амьтныг яг хүнтэй адилхан эрхийн асуудал ярьж байгаа. Бид бол зүгээр энэ анхдагч хууль, шинэ тутам харилцаа, анх хууль ярьж байгаа учраас иүүд нөгөө тэр түвшиний асуудлыг бас иүүд оруулж ирэхээр арай.../минут дуусав./

Б.Саранчимэг: Энхбаяр гишүүнд 1 минут өгье.

Б.Энхбаяр: Хуурай хууль болчих гээд байсан учраас алхам алхмаар гэдэг зарчмыг баримталж хуулийн төслөө хийсэн юм. Өөрөөр хэлбэл манай яг хуулийг харах юм бол мэдээж анхан шатынх биш. Дундад түвшинд бид барьж хуулиа хийсэн. Дундаж түвшинд. Өөрөөр хэлбэл амьтны хүний нэгэн адил нэгдүгээрт эрхийг яриагүй. Саяын Дамдинням гишүүнтэй холбоотой тэр дуу чимээний тусгаарлалттай холбоотой барилгын стандарт, нормтой холбоотой асуудлууд иүүд энэ орон сууцад амьтан тэжээж болохгүй гээд хэлчих гэхээр 12 хувь нь одоо тэжээж байгаа хүмүүс. Энэ хүмүүсийн асуудлыг яах вэ гэдэг. Энэ чинь бас эрхийн асуудал болчхож байгаа юм. Одоо ингээд бид нар бол стандарт яривал нэлээн өндөр стандартууд ярина. Жишээлбэл нохойны уяаны уртын хэмжээг бид.../минут дуусав./

Б.Саранчимэг: Баярлалаа. Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Хуулийг дэмжиж байгаа. Энэ Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дэмжиж байгаа. Асуух 2 асуулт байж байна.

Ер нь энэ нохой муур хаана их үржээд байна гэдэг асуудал дээр бид нар их онцгой анхаарах хэрэгтэй. Энэ алслагдсан бүс нутагт амьдарч байгаа хүмүүс л нохой муурыг их хэмжээгээр тэжээдэг шүү дээ. Тэгээд үржээд олон болохоор нь яадаг гэхээр төв суурин газруудаа бараадуулж хаядаг. Гөлөг байхад нь. Тэгээд ийм асуудал байдаг. Аймаг орон нутаг ч гэдэг юм уу, аймаг, нийслэл ч гэдэг юм уу жилдээ 1 удаа устгалын ажил явуулдаг. Энэ хэзээ явдаг гэхээр 11 сард, нэг бол өвлийн эхэн сард устгалын ажлыг хийдэг. Түрүүн хэлдгээр яах аргагүй л буудаж алдаг. Одоо энийг буудаж алдаг болон устгадаг хүнгүй болсон. Олдохоо больсон.

Тэгэхээр энэ хууль дээр энэ нохой, муурыг ч гэдэг юм уу энэ зэрлэг, эзэнгүй байгаа нохой, муурыг устгах, бууруулах ямар заалт орсон юм бэ гэдэг дээр нэгдүгээрт 1 асуулт асууя.

Хоёр дахь асуудал дээр энэ хууль дээр сая Дамдинням гишүүн бас тодорхой ярьчихлаа л даа бас давтаад хэлчихье. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, аймаг, нийслэл, сум дүүргийн ерөнхий төлөвлөгөө гэж байж байгаа. Хот хөгжлийн төлөвлөгөө гэж байж байгаа. Энэ дээр юу гэдэг юм Хөгжлийн төлөвлөгөө дээр энэ гэрийн тэжээвэр амьтныг тэр салхилуулдаг, гаргадаг тэр орчныг бас оруулах тийм заалт орсон уу? Энэ бол хамгийн чухал заалт шүү.

Ерөөсөө нийтийн томоохон хэмжээний орон сууцын хороололд барьдаг ямар ч зам талбай байхгүй, ногоон байгууламж байхгүй, саравч нохой салхилуулах газар байхгүй. Ийм л барилга байгууламж барьж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хууль дээр бас давхар энэ заалт орсон уу? Ер нь аймаг, нийслэл болон шинээр баригдаж байгаа барилга байгууламж дээр энэ гэрийн тэжээвэр

амьтны энэ салхилуулдаг ийм орчныг бий болгох ийм заалт орсон уу гэдгийг асуумаар байна.

Гурав дахь асуудал яах аргагүй та хэдийн хэлж байгаа үнэн. Сүүлийн жилүүдэд яах аргагүй энэ хүний болон малын гоц халдварт өвчний асуудал ярьж байгаа. Шүлхий өвчин, цэцэг өвчин гээд мал дээр ярьж байна. Хүн дээр ч гэсэн олон төрлийн ийм өвчний асуудал ярьж байна шүү дээ. Энэ асуудал мөн ялгаа байхгүй энэ зэрлэг ан амьтнаар л дамжиж халдварлаж байгаа.

Бид нар шүлхий өвчин ч юм уу, цэцэг өвчин гарахаар яадаг гэхээр нөгөө зээр болон хулангаа ч гэдэг юм уу бусад төрлийнх нь зэрлэг ан амьтныг л хардаад л. Ерөөсөө энэ Хятадын хилчид мөн бусад хил давж орсон энэ зэрлэг амьтан энэ шүлхий өвчин болон цэцэг өвчнийг халдаагаад байна л гэж ярьдаг шүү дээ. Яг нидэр дээрээ одоо бид нарын ойр орчимд байж байгаа энэ зэрлэг бусад төрлийн нохой болон муураас халдаж байх ийм магадлал өндөр байж байгаа юм.

Тийм учраас энэ тал дээр ямар зохицуулалт орсон бэ гэдэг дээр ийм 3 асуулт дээр хариулт авъя. Баярлалаа.

Б.Саранчимэг: Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Нэмээд бас манай ажлын хэсгээс нэмээд хариулаарай.

Энхтүвшин гишүүн бас яг энэ нохой, мууртай холбоотой асуудлыг бас нүүр тулж байсан бас их нарийн асуултуудыг асууж байна мэдээж. Үнэхээр энэ нохой, муурын устгах асуудлыг одоо ямар нэгэн хууль эрх зүйн орчин байхгүй, ямар ч хууль эрх зүйн орчин байхгүй.

Одоо энийг яаж зохицуулж байна вэ гэхээр ерөөсөө аймаг, нийслэлийн иргэдийн хурлуудаар 1 дүрэм гаргаад

өөрсдөө тэгээд нэг юм зохицуулаад байгаа юм. Түр зуур ийм түр маягийн тийм дүрмээр зохицуулаад байгаа юм. Энэ их олон асуудал байгаа. Энэ нохой, мууруудыг бүгдийг нь бүртгэлжүүлээд чин суулгаад, үржлийг нь хаагаад ингэх юм бол энэ нөгөө талаасаа орон нутгийн татварыг бас бүрдүүлэх 1 орлогын 1 эх үүсвэр байгаа. Үүгээрээ эргээд тэр орчныг нь бүрдүүлэх асуудал дээр зарцуулах ёстой. Мэдээж бусад улс оронд зарим хөгжингүй улс орнуудад зөвхөн нохой муурыг салхилуулах бүүр ийм цэцэрлэгт хүрээлэн, талбайн нутагтай байгаад байгаа байхгүй юу. Бүүр ингээд хаягтай зөвхөн нохой муураа салхилуулдаг. Бид бол одоо мэдээж юун нохой, муур салхилуулах тусдаа талбай битгий хэл хүн, хүүхэд тоглох талбайгүй болчихоод байгаа манай Улаанбаатар.

Тэгэхдээ бид дараагийн үе шат руу энийг журамлаж бодлогоороо чирэх ёстой. Чирэх ёстой. Жишээлбэл, Улаанбаатар хотын төв паркийг Улаанбаатар хот болон Оюутолгой компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд тохижуулах гэж байна шүү дээ. Энэ дотор бас яг зөвхөн нохой, муураа салхилуулдаг ийм талбай үүсэх асуудал бас яригдаж байгаа юм байна лээ.

Тэгэхээр энэ бол ингээд алхам алхмаар бид нөгөө дараагийн үе шат руугаа явж байгаа. Энэ үнэхээр хүмүүс чинь их шинэхэн дээрээ соохолздог, шохооргол гэдэг ч золиг юм. Тэгээд нөгөө хүүхдүүд ч амьтанд их хайртай шохоорхдог нөгөө аав, ээжүүд чинь эрхлүүлдэг, сайхан гөлөг аваад өгчихдөг тэгээд эрхлүүлж байгаад сонирхол нь буурдаг. Буурахаар нь яах вэ нөгөөдхийг чинь гаргаад хаячихдаг. Нөгөө гөлөг төөрүүлнэ гэж ярьдаг. Гөлөг төөрүүлдэг, муур төөрүүлдэг, нохой төөрүүлдэг.

Ингээд өнөөдөр Улаанбаатар хотыг харах юм бол та бүхэн хэрвээ анзаарах юм бол 5, 10 жилийн өмнөхтэй харьцуулиггүй бусад улс оронд өндөр үнэтэй зарагддаг, байдаг ийм үүлдрийн

эзэнгүй нохой маш их болчихсон байгаа. Та бүхэн их анзаарах юм бол. Энэ юу хэлээд байна вэ гэхээр ерөөсөө энэ нөгөө өндөр үнэтэй тэр нохойнуудыг ингээд л гаргаад хаяад байна гэсэн үг.

Тийм учраас энэ устгал дээр манай ажлын хэсгийнхэн нэмж хариулах байх. Энэ дээр бас сэтгэл сэртхийлгэм зөндөө л зүйл байгаа юм байна лээ. Энийг тэгээд яаж шийдэх вэ гэдэг.

Жишээлбэл Бат-Үүл бол шатаах зуух барьсан гэж байгаа юм. 500 сая төгрөгөөр. Нийслэлийн хөрөнгөөр шатаах зуух 500 сая төгрөгөөр барьсан. Энэ зуухных нь байна шүү дээ. Зардал ачаалал гэж юм ярих юм бол өдөрт нөгөө бидний устгах ёстой гээд байгаагийнхаа ерөөсөө хэдхэн хувь ч хүрдэг юм дээ. 10 хувийг л устгах боломжтой. Тэгээд бид нар бүгдийг нь устгана гээд дахиад 10 зуух барих уу, үгүй юү гэдэг. Үүний чинь нөгөө түлш шатахууны зардал нь дийлддэггүй гэж байгаа байхгүй юу.

Тийм учраас одоо энэ асуудлыг бас манай ажлын хэсгийн гишүүн бас нэмж Зориглон бас хариулах байх 3 номер.

Б.Саранчимэг: 3 номерын микрофоныг өгье.

Ц.Зориглон: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. “Азтай савар” төрийн бус байгууллагын тэргүүн зориглон байна. Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Энэ үржлийг яаж хянах вэ гэж. Тэгээд манай хуулийн төсөл дээр ер нь хамгийн эхэнд хийх чухал юм ерөөсөө бүртгэл гэж явж байгаа юм. Тэгэхлээр нохой, муур тэжээгч, асран хамгаалагч нарын нохой, муураа маш нарийн бүртгэлд оруулах ёстой юм байна. Одоо энэ бүртгэлийн систем бол ерөөсөө зүгээр 1 айлын хаяг дээр байгаа. Бид нарын төслийн дагуу нохой, муурыг зөвхөн тэр гэр бүлийн 1 гишүүн дээр байх

ёстой гэж үзэж байгаа бүртгэл нь. Энэ бүртгэлийг хангалттай сайн хийснээрээ энэ үржлийг хянах боломжтой гэж үзэж байгаа юм. Үржлийг сайн хянаснаараа ямар үр дүн гаргах вэ гэхээр нөгөө цаашдын гудамжинд гарч хаягдаж байгаа нөгөө устгалд орох шаардлагатай болоод байгаа амьтад үүсэхээс сэргийлнэ гэсэн үг.

Тэгэхлээр бид нарын энэ бүртгэл, спэй энэ тэр ингээд хийгдээд яваад ирсний дараа энэ устгал гэдэг асуудал байхгүй болж нөгөө түрүүний таны асуултад орсон нөгөө гадаа хаягдаж байгаа, ууланд гарч байгаа энэ амьтад үүсэхгүй байх нь нөхцөл нь бүрдэнэ гэсэн үг болж байгаа юм.

Тэгээд орон нутагт жишээ нь бас яг л ялгаагүй замбараагүй үржүүлэг явж байгаа. Бүртгэлгүй, хяналтгүй үржүүлэг явж байгаа учраас түрүүний халдварт өвчний асуудлууд бас ялгаагүй гарч байгаа юм байна лээ. Манай байгууллага руу хэд хэдэн аймагаас бас холбогдож байсан. Яг энэ бүртгэлийн асуудал нохой, муурын үржилтийг зогсоох асуудлыг бас аймагтаа хэрэгжүүлэх хүсэлтэй байна гэдэг хэд хэдэн аймаг холбогдож байсан учраас тэд нартаа бас илүү мэдээлэл өгөөд, энэ бүртгэлийн систем, үржлийг зогсоох асуудлыг бас орон нутагт сумын хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж өгч болохоор юм шиг харагдаж байсан.

Түрүүний тэр нөгөө гишүүн Энхбаяр гишүүний хэлсэн үүлдэр ноход маш ихээр гудамжинд хаягдаж байгаа гэдэг нь бас мөн ялгаагүй нөгөө бүртгэлийн асуудал дээр дахиад л очиж байгаа юм л даа.

Яагаад гэхлээр нөгөө замбараагүй үржүүлгийг хийж байгаа. Жишээ нь санхүүгийн нөгөө цалингаас гадуурх орлого маягаар харж үржүүлж байгаа маш их хүмүүс байгаа. Тэд нар маань ямар ч бүртгэлгүй, хяналтгүй. Дээр нь юу үйлдвэрийнхээ нөгөө онцлог шинж чанарыг хадгалаагүй тийм хяналтгүй үржүүлэг явуулснаараа эргээд нохой,

муурын үнэ цэн унаж үйлдвэрийн ноход маш ихээр гарах нөхцөл нь бүрдээд байгаа.

Б.Саранчимэг: Баярлалаа. Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.

Г.Мөнхцэцэг: Монгол Улсын хэмжээнд нийт өрхийн ер нь 25 хувь нь гэрийн тэжээвэр амьтантай гэсэн тоо гарсан байна. Үүнээсээ гэр хорооллын 54 хувь нь, орон сууцын өрхийн 12 хувь нь нийтдээ ер нь үндсэндээ 98800 тэжээвэр амьтан нийслэлийн хэмжээнд байна гэж та бүхэн маань энэ танилцуулгадаа ирүүлсэн байна.

Тэгэхээр энэ мэдээж хууль гарснаараа хариуцлагажуулах, эзэнжүүлэх гэдэг зохицуулалт илүү түлхүү туссан байх гэж ингэж ойлгогдож байна.

Нөгөө талаасаа ер нь одоо 21 оны тооллогоор үндсэндээ 1 энэ 320 гаруй мянган эзэнгүй муур, нохой байна гэж та бүхэн бас энэ бүртгэлдээ хамруулсан юм шиг байна. Нийслэлийн хэмжээнд одоо 100000 нохой, муурыг устгахаар жилдээ ингэж төсөвлөдөг гэж ингэж танилцуулгад туссан байна.

Тэгэхээр мэдээж энэ бид нар энэ эзэнгүй муур, нохойг устгах ийм эрх зүйн зохицуулалт байхгүй байна гэж бүгдээрээ хэлж байна. Ер нь яг томъёолоод яаж ингээд устгах тал дээр нь ийм зохицуулалтуудыг энэ хуульд оруулаад ирэв? Энэ дээр яг яаж томъёолж оруулж ирснийг нь нэг хэлээд өгнө үү гэж ингэж бодож байна.

Ер нь дэлхий нийтэд 124 улс ийм хуультай юм байна шүү дээ. Монгол Улс анх удаагаа бас ийм хуультай болох гэж байгаа юм байна. Тэгэхээр ийм нөхцөл байдал үүссэн тохиолдолд бид нар ялт ч үгүй ийм хуультай болох нь зөв зүйтэй гэж бас та бүгдийн гаргаж байгаа санал санаачилгыг бас дэмжиж байгаа юм.

Монгол Улсын хувьд бас онцлог байгаа. Та бүхэн бүгдээрээ бас мэдэж байгаа байх. Ер нь бас хөдөө орон нутаг гэх энэ малчдын өрхүүд гээд ингээд мэдээж гэрийн тэжээвэр нохойгүй өрх гэж огт байхгүй. Тэгэхээр энэ бас бидний онцлог. Хот суурины ажил амьдралтай өрхүүдэд бас арай өөр зохицуулалтууд бас байгаа байх. Тэгэхээр ер нь хот хөдөөгийн ялгаа, ялангуяа яг энэ гэрийн тэжээвэр амьтан дээр ийм зохицуулалтыг бид нарт бас онцлог байгаа учраас ийм тусгайлан онцгойлон заасан тийм тусгай зохицуулалт байна уу, үгүй юү? Тийм. Энэ дээр нэг хариулт авчихъя.

Б.Саранчимэг: 1 номерын микрофоныг өгье.

З.Золзаяа: Сайн байцаана уу? Хуульч Золзаяа байна. Мөнхцэцэг гишүүний асуусан асуултад хариулъя. Түрүүн хэлсэн зөвхөн нийслэлийн хэмжээнд албан бус тоогоор 200-300000 орчим эзэнгүй нохой, муур байна гэсэн ийм албан бус тоо байдаг. Юуны өмнө энэ амьтдыг яаж устгах вэ гэдэг асуудлыг ярихаасаа илүүтэйгээр яагаад ийм нөхцөл байдал үүсчхэв гэдгийг шалтгаан нөхцөлийг бас товчхон дурдах хэрэгтэй байх.

Монгол Улсын хувьд түрүүн бид нарын хэлээд байгаа гэрийн тэжээвэр амьтантай холбоотой энэ харилцааг зохицуулсан ийм хууль, эрх зүйн орчин хангалтгүйн улмаас нэгдүгээрт энэ нохой муурын үржүүлэг гэдэг зүйл өөрөө маш хяналтгүй, замбараагүй болсон. Зөвхөн эдийн засгийн ашиг олох зорилгоор эд зүйл мэтээр нохой, муурыг худалдаалдаг, гар дамжуулан худалдаалдаг. Фейсбүүк болон зарын группүүдээр нохой, муурыг зүгээр нэг эд зүйлээр солих ийм явдал түгээмэл болсон.

Нэг талаасаа ингээд үржүүлэг байгаад байна. Нөгөө тал яагаад үржүүлэг байгаад байгаа гэхлээр энэ замбараагүй, хяналтгүй худалдаанаас болоод ийм эрэлт нь байгаад байгаа

хүмүүс ямар ч эзэд нь нохой, муурыг худалдаж авахдаа тодорхой хариуцлага хүлээдэггүй, өөрсдийнхөө нэр дээр бүртгүүлдэггүйн улмаас зүгээр сэтгэлийн хөдөлгөөнөөрөө хүүхдүүдийнхээ зугааг гаргах зорилгоор өөрсдөө уйдаад ч гэдэг юм уу, хөөрхөн болохоор нь гэдэг ийм байдлаар нохой, муурыг авч тэжээж байгаа.

Үүний үр дүнд дээрээс нь спэй заслага буюу нохой, муурын үржил хязгаарлах мэс ажилбарыг хангалтгүй хийлгэдэг ийм байдал байгаа. Тэгэхлээр нэг ёсондоо ямар ч хяналтгүй, замбараагүй үржүүлээд энийг нь хэн дуртай нь сэтгэлийн хөдөлгүүр худалдаж аваад ингээд хэрэгцээ шаардлага нь байхгүй болохоор ч юм уу гөлөг, муужгай нь том болохлоор гаргаад хаячихдаг. Ерөөсөө л энэ нөхцөл байдлаас болоод энэ эзэнгүй амьтад гудамжинд өнөөдөр нийслэлийн хэмжээнд гэхэд хоёр, гурван зуун мянган эзэнгүй амьтантай болох нөхцөл байдалд хүрээд байгаа юм.

Тэгэхлээр энэ хуулийн төслийн нэг зорьж байгаа зүйл бол эзэнгүй амьтны тоо толгойг бууруулах. Зөвхөн энэ эзэнгүй амьтны тоо толгойг бууруулах гэдгээрээ зөвхөн устгал гэж ойлгож болохгүй. Устгалтай тодорхой хугацаанд хэрэгжих мэдээж шаардлагатай. Өнөөдөр хуулийн төсөл батлагдаад маргааш энэ хоёр, гурван зуун мянган амьтан байхгүй болчихгүй. Тэгэхлээр үүнтэй зэрэгцээд энэ хуулийн төслөөр зорьж байгаа зүйл бол эздийн хариуцлагыг нэмэгдүүлэх, нохой, муурыг ялангуяа эздийн нэр дээр бүртгэх замаар тодорхой үүрэг хариуцлага ноогдуулах замаар эздийг илүү хариуцлагатай болгох.

Үүнээс гадна үржүүлгийг зөв зөвшөөрлийг энэ хуулийн төслөөр зохицуулж өгсөн байгаа. Тэгэхлээр энэ үржүүлгийн зөвшөөрлийг илүү хяналтад оруулах энэ замбараагүй зүгээр хашаандаа хэд хэдээр нь өвлийн хүйтэнд ингээд нохой, муур тэжээж байгаа,

үржүүлж байгаа байдлыг хяналтад оруулах татварын хяналтад оруулах ийм байдлаар эзэнгүй энэ суурь шалтгаан болоод байгаа нөхцөл байдлуудыг нь бууруулах замаар энэ эзэнгүй амьтны тоо толгойг бууруулах боломжтой гэж үзэж байгаа.

Үүнээс гадна эзэнгүй амьтны тоо толгойг бууруулах дээр баримтлах тодорхой зарчмуудыг энэ хуулийн төсөлд зохицуулж өгсөн. Үүнээс нь дурдах юм бол харгис хэрцгий аргыг хэрэглэхгүй байх. Түрүүний хэлсэн 180 орчим орны нэгдэн олсон энэ газрын амьтны кодекс гэдэг дээр тухайн улс орон өөрийнхөө нөхцөл байдалд тохирсон байдлаар энэ эзэнгүй амьтны тоо толгойг бууруулах арга хэрэгслийг хэрэглэж болохоор заасан. Үүнд заасны дагуу амьтанд нь харгис хэрцгий байдлаар бус аль болох энэрэнгүй энэ арга хэрэглэхээр энэ зарчмыг хуулийн төсөлд тусгаж өгсөн байгаа.

Б.Саранчимэг: Туваан гишүүн. Энхбаяр гишүүн нэмж хариулъя.

Б.Энхбаяр: Мөнхцэцэг гишүүн бас аягүй чухал асуудал хариуцаж асуудлаа. Энэ зүгээр нохой, муурын тухай хууль биш. Их анзаарах юм бол би түрүүн хайрын тухай хууль гэсэнтэй адилхан. Энэ мөн соёлын тухай хууль байгаа. Яагаад гэхээр манайх одоо нүүдлийн иргэншил соёлтой, нохойгоо өөрийг хамгаалагч, мал сүргийг гаднын хээрийн боохойноос хамгаалагч гэдэг, эд хөрөнгийг хамгаалагч гэдэг ийм соёлын онцлогтой.

Манайх ер нь 3 хөөрхөн гэдэгтэй бол гөлгийг оруулдаг шүү дээ. Ертөнцийн 3 хөөрхөн гэдэгт амьтны тэр үр төлийг оруулдаг. Бид бас тэр амьтантай харьцах их уламжлал соёлын бас их онцлогтой. Сүүлийн энэ суурин иргэншил соёл буюу хотжилт явагдаж байгаатай холбоотойгоор яг энэ амьтанд хандах соёлын ялгаа илтэд анзаарагдаж байгаа юм. Хөдөө нэг өөр, хотод нэг өөр. Хөдөө бол нохойгоо гэртээ оруулна гэдэг

ойлголт байдаггүй. Нохой бол гэрт ордог амьтан биш байхгүй юу. Хөдөөгийн малчдын хувьд.

Хот сууринд амьдарч байгаа хүмүүсийн хувьд аваад үзэхээр тэр гадаа байлгана гэж байхгүй шүү дээ. Энэ чинь гэртээ цуг амьдарч байгаа гэр бүлийн 1 гишүүн гэж үзэж байгаа юм. Гэр бүлийн 1 гишүүн. Яг ийм соёлын ялгаа нь манайд хот болон хөдөөд бас ийм ялгамжтай байдлаар, хүүхдийн ч тэр, хүний ч тэр сэтгэлгээнд энэ амьтан танд хандах хандлага дээр бас тод илэрч соёлын ийм ялгаатай байдал бас их анзаарагдаж байгаа.

Тийм учраас энэ асуудлыг бас хуульчлахад үнэнийг хэлэхэд төвөгтэй байсан. Яагаад гэхээр ийм ялгамжтай соёлын харилцааг 1 уутаар зохицуулна гэдэг их амар биш, амар биш. Жишээлбэл гэр хорооллын тэр нохойны уяаны уртыг зааж өгөхгүй бол зарим энэ манай Улаанбаатар хотын гэр хороолол газар их бага. 0.07 га газар 3 айл амьдарч байна 1 хашаанд ингээд 3 гэр.

Тэгээд энэ нохойны нөгөө урт чинь их богино. Энэ нь юунд хүргэж байна вэ гэхээр нөгөө амьтны чинь илүү хүнээр бол эрүүдэн үүдэн шүүлт. Тэнд тэр амьтан чинь орчхож байгаа байхгүй юу. Богино уяатай эрх чөлөөгөө хасуулж байна, Дураараа явж чадахгүй, ингээд байнгын уяатай. Ингээд тэгэнгүүт зан авир эвдэрнэ. Хүнээр бол нохой чинь ёстой хүнийг урдаг нохой болно. Энэ, та бүхэнд судалгаанд харуулсан жилд 3800 хүн, хүүхэд нохойнд хазуулж байна гээд байгаа шүү дээ. Энэний чинь 90 хувь нь эзэнтэй нохойнууд байгаа байхгүй юу. Эзэнгүй биш. Эзэнтэй нохойнууд хүн урссан байгаад байгаа байхгүй юу. Энэний шалтгаан нөхцөлийг нь аваад үзэхээр саяын хэлж байгаа ийм олон асуудал руу ороод байгаа юм.

Тийм учраас бид нөгөө шалтгаан нөхцөлтэй нь тэмцэж энэний соёлыг түгээх, хүмүүст ойлгуулах ,стандарт бий болгох ийм олон арга хэмжээнүүдийг

л энэ хуулиар шанг нь тавих гэж байгаа ийм учир шалтгаантай. Энэ хууль маань 10 жилийн дараа гэхэд дараагийн үе шат руугаа гарна. Дараагийн илүү боловсронгуй болгосон илүү бүүр илүү хүнлэг болсон тэр үе шат руугаа би ахина гэдэгт бас эргэлзэхгүй байгаа.

Б.Саранчимэг: Баярлалаа. Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Энэ хуулийн төслийг дэмжиж байна. Цоо шинэ хууль байна. Тэгээд Монголчууд бид нүүдлийн соёл иргэнишилтэй тэгээд энэ гэрийн тэжээмэл амьтан малаас гадна түүнтэйгээ цуг нохойг гарцуулан тэжээж ингэж нохойг өөрийн нөхөр гэж үзэж ирсэн ийм уламжлалтай.

Эд хөрөнгөө хамгаалуулна, өөрийгөө хамгаалуулна, хүүхдээ хамгаалуулна. Тэгэхээр энэ нэлээн тийм хөдөө орон нутагт өөр харилцаа. Муур дээр ч гэсэн ер нь бас хөдөөгийнхөн маань, малчид маань нөгөө хэд жоохон гурилаа, идэх юмаа малын тэжээлээ хулганаас хамгаалахад их хэрэглэдэг шүү дээ тийм ээ?

Тэгэхээр энэ нэлээн тийм хөдөөд, хот суурин газар 2 дээр өөр харилцаа байгаа юм. Үүн дээр эхлээд бид хэд хүнийхээ асуудлыг ярих ёстой байх. Энд энэ талаар нэлээн хуульдаа оруулж өгөх нь зүйтэй байх. Нохойд хазуулсан хүн гээд. Батсүмбэрийн асрамжийн газарт байгаа нохойнд зүгээр хазуулаад вакцинаа тариулаагүйгээс болоод галзуурчихсан, галзуу өвчин тусчихсан ийм хүмүүс ингээд насаараа хохирч байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм асуудал байна. Энэ бас харилцааг маш хурдан ингээд зохицуулахгүй бол ганцхан тэр зооноз, антропо зооноз буюу амьтнаас хүнд халддаг халдварт өвчин биш энэ галзуугийн асуудал энэ тэр нэлээн хүнд асуудал.

Дээрээс нь энэ нохойд хазуулаад бүүр амь насаа алдсан тохиолдол хүртэл гарч байгаа. Төв аймагт ийм тохиолдол

гарсан. Ялангуяа энэ Дундад Азийн гэж нэрлэдэг энэ зодооны чиглэлийн нохойнууд хүний амь насанд хүрсэн асуудал хүртэл яригдсан. Тэгэхээр ерөөсөө хуулийг яаралтай хэлэлцэж батлах нь зөв гэж бодож байна.

Хөдөө орон нутагт энэ нохой бас зэрлэгшээд чонотой нийлээд ингээд эргээд энэ мал аж ахуй, малчдад энэ мал руу дайрах гэдэг энэ асуудал нэлээн олон газар түгээмэл болсон. Тэгэхээр хөдөө орон нутагт ч гэсэн бас энэ асуудлыг хурдан зохицуулах ёстой болж байгаа юм.

Нохойг бид нар нөхөр гэж үздэг, дээрээс нь нохой албал маш муу гэж үздэг. Нохой дайрвал гэж их цээрлэдэг ийм хүмүүс дээр энэ хөдөөгийн яг энэ хуулийг хэрэгжүүлж байгаа энэ Монгол Улсын хууль хэрэгжүүлж байгаа багийн засаг дарга, сумын засаг дарга нар дээр маш хүнд ачаа ирж байгаа. Одоо сүүлдээ нохой буудах энэ асуудлуудыг нүгэл гээд хийх хүн олдохоо больчихсон ийм хүнд хүнд асуудлууд байна.

Тэгэхээр тодорхой хэдэн асуулт асууя. Энэ харгис хэрцгий биш өөр яг ямар арга байна? Энийг нэгт хэлье. Яг тодорхой хэлээд өгөөч.

Хоёрдугаарт нь энэ гэрийн тэжээмэл амьтны татварын асуудлыг ер нь энэ хуульд нэмэгдүүлэхээр байгаа юу, ямраар байгаа юм гэдэг 2 дахь асуудал.

Энэ спэй хийлгэхэд яг бодитойгоор зардал өнөөдөр хэдтэй байна? Ямар зардлаар хийж байна гэсэн асуулт байна.

Хүн бас өөрөө нохойгоо тэжээж байгаад нөгөө нохой хөгширдөг, зөнөдөг энэ үед нь бас энэ нохойгоо жишээлбэл мал бол тэр чинь гаргаад идчихнэ шүү дээ. Тогоогоо тосолчихно. Энэ нохойгоо гэрийн тээвэр амьтнаа ер нь яах вэ? Энийг зохицуулсан харилцаа ер нь байна уу, үгүй юү? Тэгээд энэ дээр энэ түрүүн

нохой дээр зардал гараад байна гэж байна. Эргээд энэ нохойноос чинь жишээлбэл бид нар мэдэж байгаа шүү дээ нохой арьсан гутал гээд. Тэгэхээр энэ дээр тэр хэрвээ яг бодитойгоор энэ байгаа л юм чинь энийг бас ашиглаж болох тал энэ тэр дээр ажлын хэсэг дээрээ ярьсан зүйл байдаг юм болов уу гэсэн ийм асуултуудыг асууя.

Б.Саранчимэг: 1 номерын микрофон. Дараа нь Энхбаяр гишүүний, нэмэлтээр хариулчхаарай. Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Туваан гишүүний асуултад хариулъя. Үнэхээр энэ нохойг буудаж устгаж байна гээд байгаа боловчиг энэ ажлыг хийх хүн байхгүй болчихоод байгаа юм. Энэ тийм хүн дуртай хийх ажил бас биш байгаад байгаа юм. Улаанбаатар хотын хувьд гэхэд ер нь хүн олдохгүй байдаг юм байна лээ. Энэ буудаж өгөх хүн нь олдохгүй. Энэ хүмүүс нэр усаа нууцалдаг. Тэр байтугай ар гэртээ ч ийм ажил хийдгээ мэдэгддэггүй нууцлалыг хангаж бас ажилладаг юм байна лээ. Одоо байгаа хэдхэн хүн нь.

Тийм учраас энэ бас нэлээн эмзэг асуудал юм байна лээ. Их тийм дуртайдаа ер нь хийгээд байх бас ажил бас биш. Энэ чинь амьтан алаад байна шүү дээ. Нэгдүгээрх асуудал нь.

Үүнийг үнэхээр тэр устгаж ийм хурдаар явж амжихгүй. Үүний цаана бид чинь юм болгон мафи ярьдаг болсон. Яг улсын төсөв дээр нохой, муурыг устгана гэж бас нэлээн их мөнгө тавиад бас яг устгаж байна уу, үгүй юү гэдэг асуудал бас цаашаа үүсэх юм байна лээ.

Яагаад гэхээр үүний тэр бүртгэл нь яах юм, хяналт нь яах юм шатаачихсан гээд байгаа юм нь таны хэлдгээр гутал болоод явж байдаг бизнес цаана нь үүсчихсэн байна уу, үгүй юү. Эсвэл бүүр хоол хүнс рүү арай ороод явчхаагүй биш байгаа даа энэ тэр гэсэн.

Энэ чинь өөрөө тийм нарийн асуудал юм байна лээ.

Тийм учраас энийг тэр бүртгэлжүүлэх, дүрэмжүүлэх, хяналттай болгох гэдэг маань өөрөө тийм цогц энийг нэн даруй хяналтад оруулж авахгүй бол болохгүй болчихсон юм байна лээ. Бид нөгөө ямар ч энийг зохицуулсан юм байхгүй гэдгийг хэлье. Тэгээд манай ажлын хэсгийн гишүүд бас нэмж хариулъя.

Б.Саранчимэг: 1 номерын микрофоныг өгье.

Д.Оюун-Эрдэнэ: Сайн байна уу? Тухайн гишүүний 1 болон 4 дүгээр асуултад нь хариулт өгье.

Нэгдүгээрт устгал дээр ер нь өөр ямар арга хэрэглэх боломжтой юм бэ, өөр ямар аргууд байдаг юм бэ гэж асуусан. Түрүүний дурдаж байсан нөгөө дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагаас гаргасан кодексад зааснаар бол яг устгахдаа баримтлах зарчим нь хамгийн хурдан, маш шууд судсаар, өвчин намдгагчтайгаар амьтанд өвчин мэдрүүлэхгүйгээр устгахыг хүлээн зөвшөөрч байгаа.

Эдгээрээс тодорхой аргуудыг ер нь хатуу хориглодог. Энэ ямар аргуудыг хориглож байгаа вэ гэхээр химийн болон механик аргаар тухайн амьтандаа маш их өвчин зовлон мэдрүүлэх эсвэл үр дүнгүй хурдан хугацаанд гүйцэд устгал хийх ч боломжгүй гэж үзэж байгаа. Жишээлэх юм бол унтуулгагүйгээр тарих, яг зориулалтын эвтаназын бодисыг ашиглахгүйгээр өөр ахуйн бодис хэрэглэж устгах ч юм уу эсвэл механикаар гэмтээх, утах, угаартуулах, амьсгалыг нь боох гэх мэтчилэн аргыг ер нь хориглодог.

Тэгээд үзэхээр хамгийн олон улсын практикт хүлээн зөвшөөрөгдөж байгаа аргууд судсаар зориулалтын эвтаназын бодисыг мэргэжлийн мал эмнэлгийн байгууллага дээр хийх энэ аргыг ер нь

олон улсад хамгийн түгээмэл хэрэглэж байгаа. Буудах устгах арга ер нь хөгжил буурай манай улстай ижил асуудал тулгараад байгаа орнуудад ашиглагдаж байсан. Тэгэхдээ буудаж устгах дээр сүүлийн үед ер нь татгалзаад байгаа.

Орос Улсын хувьд жишээлэх юм бол 2018 онд хөл бөмбөгийн дэлхийн аварга зохион байгуулах үеэр гарсан скандалтай холбоотойгоор буудаж устгахыг хориглож эхэлсэн. Буудаж устгах нь өөрөө 10 нохой явж байхад 1-ийг нь буудлаа гэхэд бусад нь зугтаад явчихдаг. Тэгээд эргэн тойронд байгаа хүмүүсийнхээ эрүүл мэндэд хор нөлөө үзүүлдэг гэх шалтгаанаар ер нь дэмжигдэхээ больж байгаа.

Дөрөв дэх асуултын хувьд. Энэ нэгэнт эзэнгүй байгаа амьтдынхаа ашиг шим, эдийн засгийн эргэлтэд оруулах аж ахуйн байдлаар түүхий эдийг нь ашиглах боломжтой эсэх дээр хариулт өгье.

Энэ дээр юуны түрүүнд энэ эзэнгүй байгаад устгаад байгаа амьтад маань өөрсдөө ирээдүйд урт хугацаандаа бид нарын зорилт болох ийм устгах шаардлагатай амьтангүй 0 цэгт хүрэхийг зорьж байгаа. Энэ хооронд эдийн засгийн эргэлтэд оруулах буюу энэ устгаж байгаа амьтдыгаа тушаах эсвэл түүхий эдийг нь хэрэглэх ийм бизнесийн ашиг эдийн засгийн эргэлт үүсээд ирэхээрээ энэ асуудал маань өөрөө 0 цэгтээ хүрэхгүй үргэлжлээд байх ийм сөрөг үр дагаврыг бий болгоно.

Энэ дээр манай улсад ч гэсэн бусад улсад ч гэсэн гишүүн туршлагауд байдаг. Түүрүүн Энхбаяр гишүүний дурдаж байсан шатаах зуухны ашиглалтад орох үеэр манайх нохой, гөлгийг үнэлж худалдаж авах тийм зар гаргаж байгаад үүнтэй холбоотойгоор эргээд өөрсдөө хашаандаа маш их олон гөлөг үржүүлээд аваачиж тушаадаг ийм байдалд гаарсан, даамжирсан. Эргээд энэ асуудал маань улам асуудлаа шийдэхээсээ илүү хэтэрч байсан. Үүн шиг ер нь олон улсад “Кобра эффект” гэж

ярьдаг нөгөө хорт могойноосоо салахын тулд худалдаж аваад байсан чинь улам олироод байдаг. Тэгээд эргээд энийгээ цуцлангуут олон үржчихсэн могойгоо гаргаж хаяад бүүр асуудлаа дийлэхгүй болж байсан ийм гишүүн туршлага байгаа болохоор эдийн засгийн эргэлтэд оруулахыг бид нар дэмжихгүй байгаа.

Б.Саранчимэг: 4 номерын микрофоныг өгье.

Ц.Болормаа: Сайн байцгаана уу? Өнөөдрийн мэндийг хүргэе. Намайг Болормаа гэдэг. “Азтай савар” төрийн бус байгууллагын гишүүнээр ажилладаг. Би гишүүний 3 дахь асуудал буюу спэй зардлын талаар та бүхэнд тодорхой, бяцхан бид нар мэдээлэл өгье. Спэй заслага буюу эм амьтан нохойн муурын үржлийг хязгаарлах мэс ажилбар маань тухайн амьтны амьдын жингээс хамаараад охин нохой, муур дээр 90 мянгаас 120 мянга. Нохойн дээр амьдын жингээсээ хамаараад 120-350000 хүртэл төгрөг бид нарын судалгаагаар гарсан байгаа. Дундажлаж гаргасан байгаа.

Үүн дээр бас нэмэх нь эр нохой, муур дээр арай үнийн хувьд харьцангуй бага. Эр муур дээр 80000-100000 төгрөг. Эр нохойн дээр болохоор 90000-250000 төгрөг гэдэг тоог бид нар гаргасан байгаа. Энэ дүнгээрээ ингээд үзэх юм бол нэлээн өндөр дүн гарч байгаа. Өндөр дүн гарч байгаа ч гэсэн эргээд энэ маань тухайн амьтны үржлийг нь хаачих юм бол бид устгах гэдэг, буудах гэдэг аргыг заавал ашиглаад байх шаардлагагүй. Тэр өндөр бид нар устгах ажлын тэр төсвийг төсөвлөх шаардлагагүй болох боломжтой болох юм. Энэ мэдээж урт хугацааны асуудал үүснэ.

Түүрүүн нөгөө гишүүд ярьж байсан хөдөөгийн нохойнууд болон орон нутгийн нохойнууд харьцангуй өөр байдаг гээд. Мэдээж орон нутгийнх нь нохойнууд сул чөлөөтэй мал, амьтнаа хамгаалаад, хотоо хамгаалаад байдаг харьцангуй орон сууцад болон энэ гэр хороололд

байдаг нохдыг бодвол харьцангуй чөлөөтэй амьдардаг байгаа.

Дээрээс нь манай малчид хавар болохоороо хуурга, ишгээ хөнгөлдөг байгаа. Түүнтэйгээ адилхан эр нохойнуудаа хөнгөлдөг, мэддэг, хамгийн сайн мэддэг нь малчид байдаг. Үржлийн талаар. Ер нь малчид, нохой, муурыгаа үржүүлбэ гэсэн бодол ер нь байдаггүй. Эртний аргууд байдаг. Төрсөн гөлөгнүүдийг шууд ингээд тогоо хөмөрч тавина ч гэдэг юм уу тийм ардын аргууд байдаг. Тэрнээсээ илүүгээр үржлийг нь зогсоох, засах, хөнгөлөх, үржлийг хаалгах гэдгийг малчид маш сайн мэддэг учраас бид нар энэ хууль дээр тусгаж өгсөн хөдөө, орон нутгийн малчдын нохойн дээр бид нар маш хатуу, чанга заалтууд оруулаагүй байгаа.

Б.Саранчимэг: Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Тэр татварын бодлогын талаар нь хуульд яаж орж байгаа талаар хэлээч. Дээрээс нь танин мэдэхүйн 2 асуулт. Энэ Солонгост ер нь яадаг юм? Та нар мэдэж байгаа байх. Энэ нохой иддэг шүү дээ. Махыг нь хүнсэнд хэрэглэдэг. Эд нар ер нь яаж Монголчууд бол хонь, ямаагаа төхөөрдөг шүү дээ. Түүн шиг ямар арга хэрэглэдэг юм бол? Энэ танин мэдэхүйн асуулт.

Дараагаар нь Бейсен гишүүн байна бид 2 бас анагаахад сурч байхдаа нохойг барьж аваад бид нар бас туршилтад ашигладаг, дадлага хийнэ, олгойг нь авна, гэдсийг нь тайрна. Тэгэхээр ийм зүйл рүү бас ашиглаж барьж болох талаар юм байдаг юм болов уу гэсэн танин мэдэхүйн асуулт.

Б.Саранчимэг: 4 номер хариулъя товчхон, тодорхой хариулчхаарай. 4 биш 2 номер юм байна шүү. 2 номерыг өгье.

Э.Бүжинлхам: Сайн байцаана уу? Намайг Бүжинлхам гэдэг. “Азтай савар” төрийн бус байгууллагын ерөнхий координатороор ажилладаг. Миний

хувьд яг энэ татварын асуудал дээр хариулт өгье гэж бодож байна.

Татварын тухайд Татварын ерөнхий хуульд тухайн орон нутгийн засаг захиргаа нохойнд татвар тавих хэмжээгээ өөрсдөө тогтооно гээд заасны дагуу тэрийг баримталж байгаа.

Сүүлд Татварын ерөнхий хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр энэ нь нохой болон муур гэж өөрчлөгдөөд явж байгаа юм байна лээ. Тэгэхээр яг энэ хуулийг татвар, тэгээд энэ манай хуулийн хувьд бол хуулийн төслийн хувьд яг энэ заалтыг дагаж байгаа юм. Яг заагаагүй, орон нутгийн засаг захиргаа нь өөрсдөө тогтооно гээд явж байгаа юм. Тийм.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр өнөөдөр бид нар бас маш чухал хуулийн төслийг хэлэлцэж байгаа. Энэ Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль өмнө нь ямар ч хууль, эрх зүйн зохицуулалт байгаагүй.

Тэгэхээр энэ хууль, эрх зүйн зохицуулалтыг оруулж ирж байгаа бас ажлын хэсэг болоод санаачлагчид баяр хүргэе. Тэгээд бид нар их чухал хууль батлах ёстой. Энийгээ өнөөдөр жишээ нь зөвхөн нохой, муур яриад байна шүү дээ бид нар тээ? Сүүлийн үед иргэд маань орон сууцанд энэ нохой, муурыг тэжээх их болсон. Тэгээд тэр дундаа бас иргэдийн дунд энэ орон сууцанд амьдардаг нохой, муурын асуудал бас нэлээн зөрчилтэй болоод байгаа энэ цаг үед энэ бас зөрчлийг зохицуулахаар ингэж оруулж ирж байгаа нь бас сайн хэрэг байна.

Энэ гэрийн тэжээвэр амьтан нохой, муур, бусад амьтан гэсэн ийм томъёолол орж ирсэн байгаа. Тэгэхээр бусад амьтан гэдэгт ямар амьтад орж байгаа вэ? Зэрлэг байгальд байдаг амьтдыг бас тэжээдэг. Тэгэхээр энэний зохицуулалт яг байгаа юу? Энэ дээр яг тодорхой хариулт өгөөч. Энэ зохицуулалтаар тэр бусад гэдэг амьтанд ямар амьтад орж байгаа юм бэ?

Дараагийн 1 асуудал бол энэ эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах үүднээс энэ тэжээвэр амьтныгаа бүртгүүлээд, вакцин мөн бүүр цаашилбал туулга хийлгэх гээд ингээд өөрсдөө орон сууцад амьдарч байгаа хүмүүс нохой, муураа энэ гэрийн тэжээвэр амьтнаа арчлаад эрүүл мэндийг нь энэ бас хангаад явж байгаа шүү дээ . Бусдадаа ч гэсэн халдварт өвчин халдаахгүй. Тэгвэл энэ хашаанд, гэр хороололд байгаа, амьдарч байгаа энэ нохой, муурыг ямар ч туулга, вакцин хийдэггүй л гэж би хараад байгаа. Тэгэхээр энэ дээр ямар хууль үйлчлэх вэ? Энэ хэрэгжих боломжтой байгаа юу?

Сүүлийн үед бас энэ түрүүн Энхбаяр гишүүн бас хэлсэн. Үнэхээр тэр том үйлдвэрийн нөгөө үнэтэй үйлдвэрийн нохойнууд чинь гудамжинд гараад яваад байгаа. Энэ арилжааны зорилгоороо бас үржүүлчхээд гэрийн тэжээвэр нохой энэ муурын амьд амьтан гээд бүүр үнэ цэн нь буураад гадаа гаргаж хаях үзэгдэл их байгаад байгаа юм. Тэгэхээр энийг хуулийн төсөлд зөвшөөрөлгүй нохой үржүүлэх мөн гэрийн тэжээвэр амьтнаа гаргаж хаяхыг хориглосон байгаа. Тэгэхээр энийгээ хэрэгжүүлэх, мөн хяналт тавих боломжтой байгаа юу гэсэн ийм асуултыг яг тодорхой асууя.

Энхбаяр гишүүн хариулах уу? 4 номер.

Э.Анударь: Анударь байна. Тэгэхээр манай хуулийн төсөлд гэрийн тэжээвэр амьтан гэсэн тодорхойлолт дээр яг ингээд нөгөө бусад амьтан гээд энэ нь болохоороо Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль дээр 4.1.1, 4.1.2, 4.1.3-т зааснаас бусад амьтан. Энэ нь юу вэ гэхээр мал байгаа. Энэ угаасаа 5 хошуу мал эд хөрөнгө гэж явна. Үндсэн хуульд зааснаараа гэрийн тэжээвэр амьтантай холбоотой яг тэр концепц зарчим үйлчлэх боломжгүй хууль зүйн хувьд.

Хоёрт нь гэх юм бол тэжээвэр амьтан байгаа. Энэ болохоор ерөөсөө гахай, тахиа гэсэн нөгөө ашиг шимийг нь

ашиглаж бусад хэрэгцээнд гэршүүлж, үржүүлж байгаа тийм амьтдыг хэлж байгаа.

Гуравт гэх юм бол зэрлэг амьтан яг энэ гэрийн тэжээвэр амьтан гэсэнд хамаарахгүй байгаа. Зэрлэг амьтныг яг энэ хуулиараа бид нар тусдаа тодорхойлчихсон. Яг гэрийн тэжээвэр амьтан гэдгээ бид нар яг амьтных нь төрөл гэхээсээ илүү яг тэжээж байгаа зорилго гэдгээр нь бид нар ялгаж өгч байгаа. Энэ утгаараа ашиг шимийг нь ашиглахаас бусад зорилгоор гэршүүлсэн хүнтэй хамт амьдрах боломжтой энэ амьтадыг ойлгоно гэж байгаа. Жишээлбэл яг гэрийн тэжээвэр амьтны зүйл буюу нохой мөртөө яг энэ Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төслийн зохицуулах харилцаанд орохгүй бас амьтад байгаа. Энэ нь жишээ нь албаны нохой, хөтөч нохой. Эдгээр манай Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төслөөр зохицуулагдахгүй. Тусдаа хуультай, тусдаа журамтай, тусдаа үржүүлэх стандарттай ийм нохойнууд байгаа.

Тэгэхээр жишээ аваад ярих юм бол албаны нохойнуудыг Тагнуулын байгууллагын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль, Хөтөч нохойг жишээ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль зэргээр тусдаа үржүүлэх, тэжээх, стандарт юмыг нь зохицуулчихсан байгаа.

Тэгэхээр бид нар энэ гэрийн тэжээвэр амьтан гэдэгт ерөөсөө яг энэ зорилгоос нь хамаарч зохицуулахаар энэ амьтдыг тодорхойлсон байгаа.

Ц.Болормаа: Болормаа байна. Түрүүн гишүүний асуусан вакцин, тулганы тал дээр би тайлбар өгье. Манай хуульд бол асран хамгаалагч буюу түр харагч нар заавал тухайн амьтандаа тодорхой насанд хүрэхэд нь вакцин, туулгыг хамруулах ёстой гээд бид хэд үүрэгжүүлээд өгчихсөн байгаа. Энэ дээр бол гэр хорооллын нохой муур дээр энэ

туулга гэдэг зүйл маш бага буюу аягүй муу гэсэн дүгнэлттэй явж байгаа. Жишээ нь энэ туулгаас үүсэж гэр хорооллын айлуудын хүүхдүүд ялангуяа бага насны насанд хүрээгүй хүүхдүүд энэ элэгний бэтэг гэдэг өвчнийг шууд халдварлаж байгаа. Энэ нохой муураас нь шууд хүнд, хүүхдэд халддаг өвчин байгаа. Энэ нөгөө зооноз өвчний бас 1 төрөл нь юм байгаа юм л даа.

Бид нар 2021 онд “Вайн Сит” гээд компаниар бид нар судалгаа хийлгэж байхад гэр хорооллын айл өрхийн 3000 нохойнд санамсаргүй түүвэрлэлтээр дээж авч үзэхэд 145 буюу 5 хувь нь бэтэг өвчин үүсгэгч, 398 буюу 13 хувь нь бусад шимэгч хорхой бүртгэгдсэн байдаг гэсэн ийм судалгаа гарсан байдаг. Энэ бэтэг өвчнийг одоо ер нь дэлхий нийтэд ядуу буурай орны өвчин гэж үздэг. Энэ юу вэ гэхээр хөрсний бохирдол, бохироос үүссэн ядуурлын өвчин гэж үздэг байгаа.

Үүн дээр бас 1 юм хэлэх юм бол бид нар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас Монгол Улсад амьтнаас хүнд халдах өвчнийг бууруулахад талаар анхааруулга удаа дараа өгч байсан. Тэрний 1 нь болохоор энэ бэтэг өвчний буюу анзаарагддаггүй өвчин гэж явж байгаа.

Тийм учраас бид нар энийг хамгийн түрүүнд чухалчилж үзээд амьтан, тэжээгч, асран хамгаалагч, түр харагч нь заавал вакцин тулганд нь хамруулж өгнө. Тулгыг улирал болгон өгөх ёстой гэсэн заалтуудыг бид нар тусгаад өгчихсөн байгаа.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр яг заалт дээр яг тодорхой ямар заалттай вэ гэж асуусан. Баярлалаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулж санал хэлэх гишүүд нэрсээ өгье. Дамдинням гишүүнээр тасаллаа. Дамдинням гишүүн саналаа хэлье.

Г.Дамдинням: Энэ хуулийг дэмжих 2 шалтгаан байгаа юм. 1 дүгээр шалтгаан бол олон нийтийн оролцоо анх удаагаа ийм өргөн дэлгэр орж ирж байх шиг байна. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын гишүүд бид нар бол ард түмний төлөөлөл. Тэгэхдээ ард түмний төлөөллийн үүргээ хэрэгжүүлэхдээ олон нийтийн санал санаачилгыг авч хэрэгжүүлэх үүрэгтэй гэдгийг хэрэгжүүлж байгаа. Эхний жишээ учраас дэмжих ёстой болчихоод байгаа юм.

Хоёр дугаар асуудал нь энэ хуулийн үндсэн зохицуулалт бол ер нь явж явж энэ Монгол орны нийт хүн амын талаас илүү нь амьдарч байгаа Улаанбаатар хотод л ер нь их. Тэгээд бас энэ Дархан, Эрдэнэтийн энд, хот суурин, төв суурин газруудад л нөлөөлөх ёстой байх. Уламжлалт аж ахуй мал ахуйгаа эрхлээд явж байгаа ард иргэд тэртээ тэргүй хуультай, хуульгүй зохицуулалтаа хийгээд явж байгаа. Түрүүн ярьж байна. Тэгээд уламжлалт аргууд байна гээд.

Тэгэхээр энэ талаасаа бодоод хуулийг өргөн барьж байгаа Энхбаяр гишүүн маань түрүүн бас хэт өндөр гэсэн утгаар эсвэл бид нар дундаж эсвэл доогуур ч гэдэг юм уу тийм маягаар тайлбарлаж байх шиг байна. Тэгэхдээ хууль тогтоогчид бид нарт хамгийн их ирдэг шүүмжлэлийн нэг бол хууль зохицуулалт бодлогын шийдвэр гарахдаа цаг үеэсээ дандаа хоцорч гараад байна гэдэг ийм шүүмжлэлийг бид нар байнга авдаг. Нэгэнт бид нар хууль тогтоох байгууллагад ажиллаад энэ улс орныг ингээд удирдалцаад явж байгаа бол цаг үеийг урьдчилж тооцоолсон зохицуулалтуудыг хийж явах ёстой гэсэн зарчмын өөр байр суурьтай байна шүү Энхбаяр гишүүнээ.

Тэгэхээр энэ зохицуулалтуудыг өргөн дэлгэр хүрээнд нь авч үзэж, хуулийн төслөө сайжруулах хэрэгтэй байна. Яг одоогийн байгаа

боловсруулалтын түвшин, хариулж байгаа байдал, нийгэм эдийн засгийн үр нөлөөг тооцсон байдал, та бүгдийн өнөөдрийн хариулж байгаа дээр бас хангалттай санагдсангүй яг үнэнийг хэлэхэд. Тэгэхдээ дэмжинэ.

Хэлэлцэх эсэхийг нь шийдсэнийхээ дараа одоо Улсын Их Хурал дээр ажлын хэсэг гараад ажиллахад энэ тооцооллуудыг маш сайн хийж зохион байгуулах хэрэгтэй байна ажлын хэсгийнхэн, Энхбаяр гишүүнээ та хэд маань бас энэ ажлын хэсгийн залуучууд. Магадгүй бас туршлага хэрэгтэй байгаа байлгүй дээ бодвол. Тэгэхээр хууль хэрэгжихтэй холбоотой нийгэм эдийн засгийн тооцооллыг нэгдүгээрт маш сайн хиймээр байна .

Хоёрдугаарт хууль хэрэгжихтэй холбоотой дагаж гарах хуулийн зохицуулалт, өөрчлөлтүүд, стандартыг өөрчлөх хэрэгтэй байна. Заавал тусгаж оруулж ирэх хэрэгтэй байна. Барилгын норм, дүрэм, стандартад хүртэл энэ орох ёстой байхгүй юу. Нэгэнт л нийгмийн оролцогч юм чинь. Оролцогч болгож бид нар зохицуулалт хийж байна шүү дээ. Тэгэхээр энийг нь тооцох хэрэгтэй байна.

Гуравдугаарт энэ уламжлалт амьдралын хэв энэ малчин ард иргэд бид нарын энэ 5 хошуу малаас ер нь яаж ялгаж авч үзэх юм? Энэ талаас нь харах хэрэгтэй байна. Тэгэхээр нэлээн өргөн дэлгэр бас progressive урагшаа харсан зохицуулалтуудыг бодож оруулж ирээрэй гэдэг ийм л хүсэлтийг өгье. Баярлалаа. Дэмжиж байгаа.

Б.Саранчимэг: Гишүүд санал хэлж дууслаа.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

72.7 хувиар санал дэмжигдлээ. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах би өөрөө танилцуулчихъя. Дараагийн асуудлыг хэлэлцье. Ажлын хэсгийнхэн болоод хууль санаачлагчид баярлалаа. Амжилт хүсье. Манай гишүүдийн хэлсэн саналуудыг маш сайн авч, дараа оруулж ирэхдээ тэн дээрээ ажлын хэсэг дээрээ маш сайн ажиллаарай.

12.11 цаг

Гуравдугаар асуудал руу оръё. Хүнс, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын цаг үеийн нөхцөл байдлын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох байгаа.

Мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд Ганхүлэг танилцуулъя. Наанаа 2 номерын микрофоныг өгье. 2 номерын микрофоныг өгье. Ганхүлэг сайд танилцуулга мэдээллээ хийе. 2 номерын микрофон асчихсан мөртөө ажиллахгүй л байх шиг байх юм. 3 номерын микрофоныг өгье дөө.

М.Ганхүлэг: Байнгын хорооны дарга, гишүүдэд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Монгол Улсын Их Хурлаас батлан хэрэгжүүлж буй Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоол Монгол Улсын Засгийн газрын “Алсын хараа-2050” “Шинэ сэргэлтийн бодлого”-д тулгуурлан 2023 оны зорилтоо тодорхойлж хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Нэгдүгээрт газар тариалангийн салбарын талаар мэдээллийг танилцуулъя.

2022 онд төрөөс тариалангийн салбарт хэрэгжүүлсэн ажил арга хэмжээ дэмжлэгийн үр дүнд 376000 га

газраас 417000 тонн үр тариа, үүнээс 394000 тонн улаан буудай, 215.5 мянган тонн төмс, 146.8 мянган тонн хүнсний ногоо, 165.2 мянган тонн тэжээлийн ургамал, 45.7 мянган тонн тосны ургамал тус тус хураан авсан нь 2021 онтой харьцуулахад төмс 18.7 хувь буюу 34000 тонноор, хүнсний ногооны ургац 23.7 хувь буюу 28.2 мянган тонноор тус тус нэмэгдсэн нь Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн үр дүн гэж үзэж байна.

Тариаланчдынхаа санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж тариалалтыг хэвийн явуулах боломжийг бүрдүүлэх зорилгоор 2022 он оны ургацаас хөдөө аж ахуйг дэмжих сан, гурилын үйлдвэрүүд болох зах зээлд худалдан борлуулсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн 193.6 мянган тонн хүнсний улаан буудай, 32000 тонн 10 нэр төрлийн хүнсний ногоонд холбогдох журмын дагуу нийтдээ 18.6 тэрбум төгрөгийн мөнгөн урамшууллыг олгосон.

Өнгөрсөн он жилүүдэд хүрсэн ажлын ололт амжилтаа батжуулан 2023 онд 393000 га-д үр тариа. Үүнээс 369000 га-д улаан буудай 70000 га-д малын тэжээл, 66.4 мянган га-д тосны ургамал, 19.8 мянган га-д төмс, 12.2 мянган га-д хүнсний ногоо тус тус тариалж, 351000 га-д урини боловсруулж бэлтгэхэд зорилт дэвшүүлэн хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Хаврын тариалалтын бэлтгэл ажлын хүрээнд Засгийн газрын 2023 оны 63 дугаар тогтоолоор хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийг арилжааны банкны эх үүсвэрээр санхүүжүүлэн Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн хэмжээг 13 хувь байхаар шийдвэрлэж, 2023 оны төсөвтөө хүүгийн хөнгөлөлтөд зориулан 135.5 тэрбум төгрөгийг тусган батлуулсан.

Энэхүү арга хэмжээний хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл эрхлэгчдэд 5-6 хувийн хүүтэй, 2-5

жилийн хугацаатай арилжааны банкны эх үүсвэрээр хөнгөлөлттэй зээл олгоно.

Газар тариалангийн үйлдвэрлэлд эргэлтийн хөрөнгийн зориулалтаар нийтдээ 120 тэрбумын зээл олгох бөгөөд үүнээс үр тариа, төмс, тос, тэжээлийн ургамал тариаланчдад 90 тэрбум төгрөг, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалагчдад 30 тэрбум төгрөг хуваарилагдаж байна.

Харин хөрөнгө оруулалтын зориулалтаар 222.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийн зээл олгоно. Үүнээс газар тариалангийн техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд 37 тэрбум, үр тарианы таримлын үтрэн байгуулахад 14.5 тэрбум, өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулахад 50 тэрбум, инженерийн хийцтэй услалтын систем байгуулахад 40.9 тэрбум, бүх төрлийн будаа, чихрийн манжин тариалах, усжуулах 27.1 тэрбум, нийслэл хот болон 21 аймагт төмс, хүнсний ногооны зоорь, аж ахуй байгуулахад 90 тэрбум төгрөг зарцуулахаар тус тус төлөвлөж, хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Улаан буудайн үрийн шинэчлэлийн эрчимжүүлэх чанар сайтай элит болон сортын үрээр тариалалт хийх боломжийг бүрдүүлэх зорилгоор дотоодын ургацаас 10.9 мянган тонн үрийн нөөц бүрдүүлсэн бөгөөд бодлогын хүрээнд хөдөө аж ахуйг дэмжих сангаар дамжуулан манай оронд тариалж нутагшуулсан болон хөрс цаг өөрийн ижил төстэй нөхцөлд тариалан эрхэлдэг Оросын Холбооны Улсын Алтайн хязгаараас нийтдээ 5.6 мянган тонн элит үр импортоор авч дотоодын нөөцтэйгөө нийлээд нийтдээ 16.5 мянган тонн улаан буудайн үрийг 30 хувийн урьдчилгаатай зээлээр олгохоор ажиллаж байна.

Төмс хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтын түвшнийг сайжруулах техник, технологийн шинэчлэл хийх зорилгоор

тухайн жилд худалдан авсан зориулалтын техникийн үнийн 50 хувийг төмс хүнсний ногоо тариалагчдад буцаан олгох бөгөөд энэхүү арга хэмжээнд зориулан 4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн.

Тариалангийн салбарт бордооны зохистой хэрэглээг төлөвшүүлэх хөрсний үржил шимийг хамгаалах, шим тэжээл бодисын алдагдлыг нөхөх, ургацын хэм хэмжээг нэмэгдүүлэх чанарыг сайжруулах зорилгоор бордоо худалдан авсан иргэн аж ахуйн нэгжид үнийн дүнгийн 30 хүртэлх хувийн татаас хэлбэрээр буцаан олгохоор төлөвлөж шаардагдах 3.9 тэрбум төгрөгийн санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлээд байна.

Хот суурин газрын иргэдийг шинэ ургацын ногоогоор тасралтгүй хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд нийтдээ 4.6 тэрбум төгрөгийн үнэ бүхий ил талбайн болон хүлэмжийн ногооны үр нийлүүлж аймгуудын хүнс, хөдөө аж ахуйн газруудаар дамжуулан олгоно. Хүнсний нарийн ногоо тариалах 20 га өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуй 500-2500 тонн багтаамжтай механикжсан агуулахын 1 маягийн зураг төслийг үндэслэн орон нутагт баригдах газар тариалангийн зориулалттай барилга байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Усалгаатай газар тариаланг 2030 онд 100000 га-д хүргэх зорилт тавьж байгаа бөгөөд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төслийн хүрээнд 40 сая долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгийг Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Завхан, Хэнтий, Дорнод, Сэлэнгэ, Төв аймагт 6000 га талбайд усалалтын систем байгуулах ажлыг хэрэгжүүлж эхлээд байна.

Алслагдсан бүс нутгийн тариаланг сэргээн хөгжүүлэх бүс нутгуудад

хүнсний улаан буудайн нөөц бүрдүүлэх зорилгоор Увс аймгийн Баруунтуруун сум, Дорнод аймгийн Хэрлэн сумд тус бүр 10000 тонны багтаамжтай үр тариа хад хадгалах элеваторыг барьж ашиглалтад оруулахаар зураг төсөв, суурийн барилгын ажлыг эхлүүлээ.

Хаврын тариалалтын өмнө тариалан бүхий аймгуудыг 6 бүсэд хувааж, шинэ залуу тариаланчдад зориулсан сургалт талбайн өдөрлөгийг Тариаланчдын холбоотой хамтран зохион байгуулж, нийтдээ 680 гаруй тариаланчдыг хамруулав.

Хоёрдугаарт мал аж ахуйн салбарын талаар.

Мал аж ахуйн салбар өвөлдөө олон жилийн дунджаас 1.1-4.2 хэмээр хүйтэн, өдөртөө 30 хэмээс давж хүй хүйтэрсэн хоногийн тоо нь олон жилийн дунджаа бас 10-15 хоног үргэлжилж. Нийт нутгийн 40 орчим хувь нь цагаан зудтай 30 гаруй хувь нь хар зудтай нөхцөлд хүндхэн өвлийг давлаа.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэд шуурхай штаб байгуулан аймгуудтай өдөр тутам холбоотой мэдээ мэдээлэл солилцон шаардлагатай асуудлыг Засгийн газар, Улсын Онцгой комиссоор шийдвэрлүүлэн ажиллалаа. Одоогийн байдлаар малчдын түвшинд бэлтгэсэн өвс тэжээл 90 хувийн зарцуулалттай байна. Аймаг, сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөц өвсний 83 хувь, тэжээлийн 76 хувийг зарцуулаад байгаа ба одоо 4.6 мянган тонн өвс, 2.8 мянган тонн тэжээлийн нөөцтэй байна.

Өнөөдрийн байдлаар 27 сая эх мал төллөхөөс 3.6 сая эх мал төллөж, 3.5 сая төл бойжиж байна. Төлөлт 13.1 хувтай, төл бойжилт 96.8 хувтай байна. Он гарсаар малын зүй бус хорогдолд 821307 толгой болж оны эхнээс 71.1 сая малын 1.1 хувьд хувийг эзэлж байна.

Засгийн газраас малчдад нийгэм эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд зориулж 8 аймагт туулах чадвар сайтай 16 автомашин олголоо. Улсын нөөцөөс 14 аймагт 1171 тонн өвс, 8624 тонн тэжээлийг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олгосон. Ховд, Архангай, Завхан аймгууд 30 тонн дизель түлш, 20 тонн А92 шатахууны бензиний дэмжлэг үзүүлсэн.

Мах бэлтгэгч 12 аж ахуйн нэгжид жилийн 3 хувийн хүүтэй 53 тэрбум төгрөгийн зээлийг олгож, Нийслэлийн хаврын махны нийлүүлэлтэд 7.8 мянган тонн мах бэлтгэсэн. Адуу, хонь, ямаан буюу махыг квотгүйгээр үхрийг 13 мянган тонн махыг экспортлохоор шийдвэрлэсэн. Энэ ажлын хүрээнд 2022 онд 16.1 мянган тонн байсан бол 2023 оны эхний 3 сард 28.2 мянган тонн мах экспортолсон. Өмнөх оны үзүүлэлтээ ахиулсан ийм үр дүн гарсан.

Мал махны эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх зорилгоор гаргасан 1 шийдвэр нь амьд малын экспорт 2022 онд 28503 толгой байсан бол 2023 он гарсаар 24540 толгой хонь, ямаа, адуу экспортолсон байна.

Бусад мэдээллийг цаасаар Байнгын хорооны гишүүд өгсөн байгаа учраас ингээд товчилъя. Баярлалаа та бүхэнд.

Б.Саранчимэг: Ганхүлэг сайдад баярлалаа. Тэгэхээр өнөөдрийн мэдээлэлтэй холбогдуулж ирсэн ажлын хэсгийг та бүхэнд танилцуулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн дэд сайд Ганхүлэг. Болорчулуун сайд Засгийн хуралтай байгаа учраас дэд сайд танилцуулж байна. Болорчулуун Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Есөн-Эрдэнэ Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Санчирдорж Хяналт шинжилгээ, дотоод аудитын газрын дарга байна.

Мэдээлэлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Туваан гишүүнээр тасаллаа. Бейсен гишүүн асуултаа асууя.

Б.Бейсен: Энэ сайдын мэдээлэлтэй танилцлаа. Хаврын тариалалт эхэлж байгаатай холбоотой энэ хүнсний аюулгүй байдалтай холбоотой Ерөнхийлөгчийн санаачилгатай холбоотой хэдэн санал хэлье.

Өнгөрсөн жил бид нар жижиг, дунд үйлдвэрлэл, газар тариалан эрхлэхэд нэлээн хэдэн зуу гаран тэрбум төгрөг тавьсан. Гэтэл үүний хэрэгжилт орон нутагт муу байна. Ихээр тариалдаг хүнсний ногоо тариалдаг улсууд авч чадахгүй. Танил тал, намын харьяаллаар аль эсвэл жижиг талбайтай хүлэмж эрхэлсэн улсууд чинь тийм улсуудад олгосон. Жишээлбэл Баяннуур сумд хуучин сангийн аж ахуй байсан. Та бүгд мэднэ. Аймгийн бүх сумдын хангаад хөри зэргэлдээ мужид хүнсний ногоо, байцай, төмс, лууван зэрэг экспортолдог байсан. Үүний хүчинд КОВИД-оор 2 жил юм нь хумигдаад л нөгөө нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй гэдгээр тэгээд нөгөөдүүл нь зээл авч чадаагүй асуудал байж байгаа юм.

Цаашидаа энэ асуудал дээр анхаараад эх орны хөрсөнд ургасан эрүүл хүнсээр ард иргэдээ хангах талын асуудал. Ялангуяа гол дагасан сумууд, тариалан эрхлэгч сумууд дээр анхаарахгүй бол болохгүй байна. Дотооддоо хүнсний ногоор хангах бүрэн боломж байгаа. Хүлэмжийн аж ахуй ч хөгжүүлэх боломж байна. Энэний цаана би ярих гэж байна гэвэл сүүлийн 30 хэдэн жил дээр нь хавдар залуужиж байна, гараагүй өвчнүүд гарч байна. Энэ ямар нэгэн хүнсний дайн явагдаж байгаа юм биш биз гэсэн хардалт төрүүлж байгаа. Ялангуяа урд хөршөөс ирж байгаа хүнсний ногоонууд чинь генийн өөрчлөлттэй, зарим нь хортой ч юм уу тийм юм гээд улсууд ярьдаг. Гэтэл энэ дээр шинжилгээ хийж байгаа юм байна уу? Нэгдүгээрт.

Одоо энэ жил тэр тариалалтын асуудал дээр нэлээн анхаарч ажиллах шаардлагатай юм шиг байна. Дотооддоо бас эх орны хөрсөнд ургасан эрүүл хүнсний ногоор хангах боломж байгаа. Энэ дээр хэр анхаарч ажиллаж байна. Цаашидаа сая нөгөө жижиг, дунд үйлдвэрлэлийн чиглэлээр газар тариалан эрхлэхэд яаж хуваарилалт гаргаж байна? Аймаг дээр хэчнээн тэрбум төгрөг тавьсан юм энийг асууя.

Хоёрдугаарт энэ махны үнэ. 80 сая малтай байж мах маань үнэтэй байна шүү дээ. Энийг буулгах юм байна уу ер нь? Буулгах боломж бий юу? Энэ махны үнийг. Дотоодын нөөцийн мах бэлдэнэ гэхээд зарим компаниуд чинь махаа дотооддоо нийлүүлэхгүй гадагшаа гаргахаар нөөцөлчихсөн асуудлууд байсан. Түрүүн Ганболд гишүүн бид хэдийг Өлгийд очиход зарим компани тийм юм гарсан шүү. Тэр талаар шалгаж хяналт тавьсан уу? Бас яг хөнгөлөлттэй зээлээ 2 удаа авчхаад, дотооддоо мах нийлүүлэхгүй гадагшаа гаргахаар ингээд ажиллаж байгаа юм. Энэ хяналт тавьж байна уу, шалгасан уу гээд асуудлаа асууя.

Б.Саранчимэг: 4 номерын микрофон хариулъя. Өөрсдийгөө танилцуулаад явчих.

Ц.Болорчулуун: Бодлого төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун Бейсен гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр өнгөрсөн жилүүдэд ер нь хүнсний хангамжийн талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хангамжийн аюулгүй байдал үндэсний хөдөлгөөний хүрээнд Улсын Их Хурал 36 дугаар тогтоолоор төлөвлөгөө баталсан. Өнгөрсөн жилийн тухайд гэх юм бол газар тариалангийн үйлдвэрлэл 100 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр гаргаснаас 72 тэрбум төгрөг нь одоо аж ахуйн нэгж иргэд авсан байгаа. 72-ын гүйцэтгэлтэй.

Хүнсний ногоон дээр 50 тэрбумын зээл гаргаснаас 28.2 тэрбум төгрөг гарсан.

Тэгэхдээ энэ бол гүйцэтгэл анх удаагаа хүнсний ногоочдод олгож байгаа зээл гэхэд гүйцэтгэл гайгүй байгаа хэдий боловч мэдээж банкны эх үүсвэрээр санхүүжүүлж байгаа учраас банкны шаардлагыг давахгүй бас эхлээд шинээр орж байгаа зээлийн түүх муутай аж ахуйн нэгжүүд хамрагдаагүй үлдсэн ийм тохиолдол байгаа.

Энэ жилийн тухайд бас бид нар энэ хүүгийн татаастайгаар газар тариалангийн үйлдвэрлэлд 90 тэрбум төгрөг, хүнсний ногооны үйлдвэрлэл 30 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэр шийдэж байгаа. Ингээд арилжааны 10 банктэй гэрээ байгуулсан. Энэ 10 банктэйгаа уулзалт хийж, гэрээ байгуулж, гарын үсэг зурах үедээ энэнээс өмнө 3 сарын туршид хамтарч ажиллах хугацаандаа энэ зээлийг хэрхэн яаж олгох вэ, ногоочдод, тариаланчдад байгаа ганц капитал бол газар байна. Энэ газрыг нь барьцаалаад олгооч, энэ дээр бас анхаараад энд хүнсний хангамжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд онцгойлон анхаараад өгөөд тийм хөнгөлөлттэй маягийн нөхцөлийг бүрдүүлж өгөөч гэдэг хүсэлтийг тавьсан.

Тэгэхдээ мэдээж банк өөрсдийн гэсэн журамтай учраас энэ журамдаа захирагдах нь зүйн хэрэг. Тэгэхдээ салбарын яамны зүгээс ийм хүсэлтүүдийг, шаардлагуудыг хүргүүлээд ажиллаж байгаа. Ингэхээр энэ жилийн тухайд бас нэлээд улс орон даяар энэ зээлийн хэрэгжилт явц бол одоо бас гайгүй харьцангуй бас өндөр хувьтай гарах байх гэж тооцож байгаа. Бид нар бүх газрууддаа хүрч зээлийнхээ хэрэгжилт дээр ингэж хамтарч ажиллахаар ингэж ажиллаж байгаа.

Мэдээж таны хэлж байгаачлан дотоодын хүнсний үйлдвэрлэлээр дотооддоо хангах ийм бүрэн бололцоо байгаа. Энэ хүрээнд нэлээд

төлөвлөгөөнүүд гараад ингээд хамтарч ажиллаж байгаа.

Баян-Өлгий аймгийн Баяннуур сум бол хүнсний ногооны тариалалтаар бас тэргүүлдэг. Хуучин алим тариалдаг энэ алимьн ургац нь одоо хүртэл ингээд тариалалт нь явагд ж байгаа ийм сум. Бид нар орон нутаг руу шаардлагатай бол энэ аж ахуйн нэгж, хоршоодтой нь бид нартай хамтарч ажиллаад, зөвлөгөө аваад энэ банкныхаа зээлд хамрагдаад явах бүрэн бололцоотой гэж ингээж харж байгаа.

Махны хувьд гэх юм бол нийслэлийн хүн амыг дотоодын энэ нөөцийн махаар хавар бас хямд үнэтэй махаар нь хангах зорилгоор өнгөрсөн жил бид банкнуудаар дамжуулж 53.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл гаргасан. Ингээд энд бол хамрагдсан аж ахуйн нэгжид 7900 тонн мах бэлтгэсэн байгаа. Энэ махны бэлтгэл болоод өнөөдрийн байдлаар нийслэлийн хэмжээнд ингээд гараад явж байгаа. Бид нар бол Засгийн газрын Хэрэг эрхлэх дээр байгуулчихсан Хяналтын газраас энэ нөөцийн махны шалгалтыг хийсэн. Нөөцийн маханд хамрагдсан аж ахуйн нэгжүүд ямар ч байсан тэр 7900 тонн махаа нөөцөлсөн байна гэдэг шалгалтын дүнгээр тогтоогдсон байгаа.

Тэгэхдээ энэ хэрэгжилт дээр, түгээлт дээр бас нийслэлийнхэн хамтарч ажиллаж, хяналт тавьж байгаа. Тэгэхээр энэ хяналт цаашидаа үргэлжилнэ. Тийм учраас бид нар нөөцийн махан дээр тавих хяналтаа сулруулахгүйгээр ингээд энэ хаврынхаа нөөцийн махны гаргалт дээр тодорхой хэмжээнд ингээд ажиллаад явж байгаа гэдгийг бас хэлье.

Б.Саранчимэг: Баярлалаа. Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.

Г.Мөнхцэцэг: Дэд сайдын мэдээллийг сонслоо. Мөн сайдын мэдээллийг цаасаар авч ингээж танилцсан. Тэгэхээр ер нь өнгөрсөн жилийн энэ ургацаас Хөдөө аж ахуйг

дэмжих санд болоод энэ гурилын үйлдвэрүүд хэчнээн аж ахуйн нэгж үр тариа, гурил будаагаа нийлүүлсэн юм бэ? Тэгээд энэ дээр хариулт өгөөрэй.

Зарим тариалагчдын хувьд болохоор энэ гурилын цавуулаг өндөртэй хэрнээсээ ялгавартайгаар ханддаг, худалдан авдаггүй, хүнд сурталтай гээд олон шүүмжлэлүүд бас дагуулдаг. Нэлээн их юм хэл ам дагуулж байсан санагдаж байна.

Тэгэхээр ер нь ер нь ямар шалгуураар тариаланчдаа дэмждэг сан юм бэ? Ер нь энэ сангийн зарцуулалт, шалгаруулалтад мөн энэ шалгалт аудитын дүгнэлт хийсэн зүйл байна уу, үгүй юу? Энэ дээр бас хийсэн зүйл байна уу? 18.6 тэрбум төгрөгийн урамшууллыг ямар шалгуураар тариаланчид олгосон бэ үр дүнг нь хэрхэн тооцсон бэ гэсэн 1 дүгээр асуулт байна.

Хоёрт энэ оны төсөв дээр 135.5 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлтөд зарцуулахаар тусгасан байж байгаа. 5-6 хувийн хүүтэй зээл олгоно гэж байгаа. Тэгэхээр энэ зээлийн шалгуурыг ямар ангиллаар олгох гэж байна вэ? Энэ дээр бас хариулт авъя.

Энэ жилийн тариалалтад үрийн сортыг сайжруулах ямар ажлыг тариаланчдад дэмжлэг үзүүлэх юм бэ? Гаднаас үр худалдан авахад хэдий хэмжээний мөнгө зарцуулахаар ингээд төсөвлөсөн байгаа вэ?

Дөрөвт нь болохоор энэ жил мал өвөлжилт хүндэрсэн нутгуудад, аймгуудад хөнгөлөлттэй өвс тэжээл хүргүүлсэн гэж байна. Ямар ямар аймгуудад өвс тэжээл хүргүүлсэн юм бэ? Ялангуяа энэ говийн бүс нутаг тэр тусмаа Дундговь бол одоо жилээс жилд дандаа ингээж хүнд нөхцөл байдалтайгаар өвөлждөг. Энэ хуваарилалтад манай Дундговь аймгийн хувьд бас хүрсэн зүйл бас байхгүй байгаа байх гэж ингээж бодож байна.

Ер нь малчид өвс тэжээлийн үнэ маш их өндөр нэмэгдсэн, хөнгөлөлттэй нөөцөөр өвс тэжээл авах бололцоо, хүрэл хэрэгцээ муутай байсан гээд ингээд жил болгон гомдол мэдүүлж байдаг.

Тэгэхээр энэ дээр ямаршүүхан зүйлүүдийг хүртээсэн юм бэ аль аймагт очсон юм бэ гэдэг дээр бас хариулт авъя. Цаашид ер нь малчид өөрсдөө бас ингээд хоршоод өвс тэжээлээ хаашаалаад ингээд авчих тал дээр бас яамнаас ямар нэгэн тусламж, дэмжлэг үзүүлэх бололцоо байдаг юм уу, үгүй юм уу? Орон нутагтаа ер нь яаж энэ чиглэлээрээ хамтарч ажилладаг юм бэ гэсэн ийм зүйлүүдийг мэдээлэлтэй холбоотойгоор асууя гэж ингэж бодож байна.

Б.Саранчимэг: 4 номерын микрофоныг өгье.

Ц.Болорчулуун: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр өнгөрсөн жил бид улсын хэмжээнд 493000 тонн үр тариа, үүнээс үүнээсээ 393000 тонн хүнсний улаан буудай хурааж авсан. Мэдээж гурилын үйлдвэрт гурилын стандарт байгаа. Тэгээд гурил үйлдвэрлэлд 193000 тонн буудай нийлүүлэгдсэн байгаа.

Дээрээс нь Хөдөө аж ахуйг дэмжих санд 30 гаруй мянган тонн хүнсний улаан буудай авсан. Ингээд энэ гурил үйлдвэрлэлд нийлүүлж байгаа хүнсний улаан буудайнд 16 тэрбум төгрөгийн мөнгөн урамшууллыг олгосон. Тэгэхээр энэ өөрөө гурилын үйлдвэрүүдэд тушаасан баримт тэгээд 2 талын тооцоо нийлсэн актыг үндэслээд урамшуулал олгодог. Энэ урамшуулал бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаман дээрээс төсөв, төсвийн урамшууллын системээр ингээд цахимаар урамшууллынхаа мэдээллийг оруулаад цахим дээр ямар нэгэн асуудалгүй бол ингээд төсвөөс урамшууллынх нь мөнгө тухайн тариаланчийн, аж ахуйн нэгж, иргэдийн дансанд орох журмаар ингээд олгогддог байгаа.

Тэгэхээр энэ дээр урамшууллын тавигдах шаардлагуудыг хангасан тэгээд будаагаа тушаасан иргэдэд энэ урамшуулал олгогддог.

Өнгөрсөн жилийн буудай хэдийгээр дотоодын хэрэгцээг хангахуйц хэмжээний буудай хурааж авсан ч 50 орчим мянган тонн буудай хүнсний улаан буудай дутагдалтай байгаа.

Яагаад гэхээр зөвхөн гурил үйлдвэрлэлд тэнцэж нийлүүлэгдэх тал дээр иймэрхүү асуудлууд гарсан. Тэгэхдээ тариаланчид дээр өнөөдрийн байдлаар ч гэсэн бас 40 орчим мянган тонн буудай байна гэсэн ийм мэдээлэлтэй байгаа.

Тийм учраас бид нар 50 орчим мянган тонн буудайгаар өнгөрсөн 2 жилийн ургацын чанартай холбоотой, чанарын асуудалтайгаар холбоотой дээрээс нь энэ дутагдаж байгаа хэмжээнийхээ буудайг импортоор оруулах ийм хүнсний Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн зөвлөмж гарчихсан ингээд ажиллаж байгаа.

Урамшууллын шалгуурыг хангасан энэ жилийн төсөв дээр 135.5 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн татаас тавьсан. Энэ зээлийн хүүгийн татаасыг хэрхэн яаж зарцуулах вэ гэдэг тал дээр бид Монголбанктай, арилжааны 10 банктai и хамтарч ажиллаад, нэр бүхий 10 банк энэ хүүгийн татаасаар зээл олгохоор өөрсдийнхөө эх үүсвэрээр зээлээ гаргаад Засгийн газрын оролцоо бол энэ 135.5 тэрбумаар буюу тухайн аж ахуйн нэгж банкны гаргаж байгаа зээлийн хүүгийн 13 хувийг Засгийн газраас төлөх нөхцөлтэйгөөр оролцож байгаа. Зээлийг олгохдоо мэдээж банкны эх үүсвэр учраас банк өөрсдийнхөө шалгуурыг тавина. Бид нар нөгөө хүнсний гол нэрийн 19 нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах том зорилтынхоо хүрээнд ямар ямар арга хэмжээн дээр хэдий хэмжээний зээл байх вэ гэдэг нарийвчилсан тооцоо, судалгаагаа гаргаад арилжааны банкнуудтай гэрээ байгуулчихсан.

Ингэхээр энэ чиглэл чиглэлээрээ зээлүүд нь олгогдоод ингээд явчих бололцоотой гэж ингээж харж байгаа.

Үр дээр бид нар түрүүчийн мэдээлэлд байгаа. Ер нь үр тариа дээр улаан буудай дээр 16.5 мянган тонн үрийн нөөцтэй байна. Энэ жил импортоор тав аравны долоон мянган тонн элит үр худалдаж авахад 9.7 тэрбум төгрөгийг зарцуулж байгаа. Энэ бол импортоор орж ирж байгаа үр. Бусад нь дотоодын нөөцөөс авсан үртэй нийлээд ингээд энэ хаврын тариалалтын үр хүрэлцээтэй гэж тооцоолж байгаа. Хүнсний ногоон дээр 8-10 төрлийн хүнсний ногооны үрд 4 орчим тэрбум төгрөгийн хүнсний ногооны үр худалдаж авах ийм тендер сонгон шалгаруулалтыг зарлаад гэрээгээ дүгнээд ажиллаж байна. Энэ хаврын тариалалтаас өмнө бас хэрэглэгчдэд хүрнэ гэж ингээж үзэж байгаа.

Аймгуудад энэ жилийн энэ өвлийн нөхцөл байдал бас хүндрэлтэй байсантай холбоотойгоор ер нь улсын нөөц гэж байхгүй. Тухайн олон улсын байгууллагын санхүүжилтээр тодорхой хэмжээний өвс тэжээлийн нөөцүүдийг аймаг орон нутагт хүргүүлсэн. Энийг аймгийн Засаг даргын Тамгын газар тэгээд Улсын Онцгой Комиссоос зохион байгуулж ажилласан. Яамнаас яг тухайлан энэ тэжээлийг орон нутагт хүргэсэн. Бидэнд ийм нөөцөлсөн асуудал байхгүй байсан. Бид бол.../минут дуусав./

Б.Саранчимэг: *Мөнхцэцэг гишүүн тодруулъя гэж байна.*

Г.Мөнхцэцэг: *Ер нь аймгуудтайгаа, орон нутгуудтайгаа хамтраад яам бас яг ингээд малчидтайгаа хамтраад энэ хоршиж тэжээл юмаа боловсруулах дээр нь бас энэ үр тариагаа бас хашаалах барих гээд ийм ажлуудыг бас хамтраад зохион байгуулж болдоггүй юм уу гэдэг ийм хүсэлтүүдийг малчид, ард иргэд маань бас ирүүлдэг л дээ.*

Тийм учраас ийм бололцоо нөхцөл нь яаманд хэр байдаг юм бэ? Энэ санаа санаачилгыг манай яамныхан ер нь яаж дэмждэг юм бэ гэдэг асуулт дээр бас тодруулаад хариулт өгчихвөл.

Б.Саранчимэг: *Хэн хариулах вэ? 4 номер хариулъя.*

Ц.Болорчулуун: *Ер нь одоо сүүлийн жилүүдэд энэ байгаль цаг уурын нөхцөл байдлаас хамаараад дээрээс нь энэ бэлчээрийн бэлчээрт ургадаг ургамлын нөхцөл байдал, энэ гангийн нөхцөл байдалтай үүдэлтэйгээр малын тоо толгойн өсөлттэй бэлчээр нэлээн даац хэтэрсэн ийм асуудал байгаа.*

Тийм учраас бид нар энэ яамнаас барьж байгаа бодлого бол ер нь газар тариалангийн бүс нутгаа түшиглэж эрчимжсэн мал аж ахуйг нэлээн түлхүү хөгжүүлж гэдэг ийм бодлогыг барьж байгаа. Үүний зэрэгцээ мэдээж бэлчээрийн аж ахуйгаа бид орхигдуулах, хаягдуулах асуудал байхгүй. Боломжтой бүх газар малчдыг хорших хэлбэрээр таримал тэжээлийг нэмэгдүүлэх энэ чиглэлд тодорхой хэмжээний бодлого гаргах, дэмжлэг үзүүлэх тал дээр бас энэ хүнсний хангамжийн хөтөлбөрт тодорхой заалтууд тусгагдсан. Энэ хүрээнд бид нар бас тодорхой хэмжээнд малчдадаа, мал аж ахуй эрхлэгчидтэй нийлээд, хоршоод энэ тэжээлийн тариалалтаар хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл нь.../минут дуусав./

Б.Саранчимэг: *Тэмүүлэн гишүүн асуултаа асууя.*

Г.Тэмүүлэн: *Хөдөө аж ахуйн мэдээлэлтэй холбогдуулан тодруулах 2, 3 асуудлууд байна.*

Нэгдүгээр асуудал яах вэ энэ жил олон жилийн дунджаас хүйтэн байсан, хур тунадас их орсон. Хүндхэн нөхцөлд ер нь өвлийг давлаа. Хавар хаваржилт бас эд дундаа ороод явж байна. Тодорхой нөхцөл байдал бас сайнгүй байна. Би ярих

гэж байгаа асуудал ер нь малчид малаа онд оруулъя гэхээр өвс тэжээлийн асуудал их хүнд байна. Өвс тэжээлийн асуудал. Та бүхэн бол аюулгүй нөөц өвсний хэмжээ 83 хувьтай, тэжээл 76 хувьтай одоогийн байдлаар нөөцтэй байна л гэж асуудал яриад байдаг.

Яг бодит байдал дээр очихоор аймаг сум дээр, орон нутаг дээр малчид дээр худалдан авах тэжээлийн хангамж хүртээмж бол байхгүй байгаад байгаа юм. Хүндхэн байна. Бүүр татаад авъя, барья гэхээр үнэ тэжээлийн хүнийг та хэд мэдэж л байгаа байх. Одоо бол зах зээлийнхээ хани нь угаасаа л энэ өвөл 20000-аас буугаагүй. Одоо жоохон буугаад 18000 болж байх шиг байна. Тэгээд л 20-25-тай л байсан.

Тэгэхээр уг нь бид нар энэ өвс тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэхгүй байх боломж бололцоо уг нь бүрэн байгаа гэж хараад байгаа юм. Хэрэгжилт амьдрал дээр хангалтгүй байгаад байдаг. Малчдын гар дээр бэлэн мөнгө байдаггүй. Ингээд малаа яаж онд оруулах вэ гэдэг л асуудал хүнд гараад байгаа юм л даа. Тэгэхээр ер нь зүгээр танай яамны зүгээс энэ өвс тэжээлийн бэлтгэлийг, нөөцийг бүрдүүлэхтэй холбоотой үнийн өсөлтийг нэмэгдүүлэхгүй байхтай холбоотой яг ямар ажлууд, ямар арга хэмжээг авч хэрэгжүүлж байна вэ? Цаашидаа яах юм бэ? Жилийн жилд л ийм асуудал үүсэж байна. Дараа жилийн асуудал дахиад л гараад үүснэ.

Хоёр дахь асуудал. Энэ ер нь аль ч аймаг, сум дээр үүссэн ерөөсөө энэ нэг асуудал нь бэлчээрийн даацтай л холбоотой асуудал байгаа юм л даа. Хүндэрсэн байдлаас болоод, дээрээс нь бид нар энэ зах зээлийг нь ойрхон болгож, борлуулалтыг нь малынх нь махыг нь борлуулж, тодорхой бодитой дэмжлэг бас үр дүн гарахгүй байгаад байгаа учраас бас л үүсээд байдаг асуудал.

Тэгэхээр энийг уг нь шийдэхийн тулд Мэндсайхан сайдын үед гарч байсан асуудал байгаад байгаа юм. Эрүүл бүсийг

байгуулж, махны экспортыг тогтворжуулах зорилго бүхий 4 бүс нутагт, 4 аймагт экспортын чиглэлтэй худалдан авагч талтай нь хамтраад махны экспортыг нэмэгдүүлэх, өөрсдийнх нь стандарт зааврын дагуу энэ тусгаарлах аж ахуй бүхий энэ махны үйлдвэрүүдийг байгуулах асуудал байсан юм. Яг л олон улсын стандартынхаа дагуу өвчингүй эрүүл бүсийг нь бий болгочихъё. Стандартад нийцүүлсэн тусгаарласан малыг тэнд нь эм тариа, вакциныг нь хийгээд хяналтад нь оруулаад, ингээд тодорхой тогтсон үнээр урагшаа зах зээл рүү гаргая гэдэг асуудлыг ярьж байсан. Урд талаас ч гэсэн Засгийн газрын зээл дэмжлэг туслалцаанд бэлэн байгаад байгаа юм.

Тэгээд энэ 2, 3 жил явж байсан зураг төсөв бүх юмнууд нь дуусчихсан ажил ингээд нам зогсчих шиг болох юм. Уг нь энийг л хийж байж бид нар ярина уу гэхээс биш жилийн жилд л нөгөө мал мах экспортолж байгааг, хагас боловсруулсан, бүтэн боловсруулсан, чанасан утсан махаа гаргаад байна гэвэл энэ чинь нөгөө яг борлуулалт хүссэн хэмжээндээ бид нар хийж чадахгүй болчихоод байна.

Тэгэхээр чөлөөтэй борлуулах гарц, нүүдэл шийдэл чинь яг л өөрсдийнх нь оролцоотойгоор хамтарч хийх гадаад зах зээлтэй нь хамтарч шийдвэрлэх л энэ асуудал байгаа юм л даа. Тэгэхээр энийг уг нь явуулаад хийчихмээр байх юм. Гадаад яам ч гэсэн энэ дээр бас анхаарал хандуулаад ингээд эрчимжүүлэх ажил руу ормоор байх юм хоёр дахь асуудал нь.

Гурав дахь нь яг энэ Байнгын хороон дээр бид нар Байнгын хороонд тогтоол гаргаад, залгуулаад Улсын Их Хурлын тогтоол болгоод Туваан гишүүн, Ж.Бат-Эрдэнэ гишүүн бид нар хамтраад өргөн барьсан батлуулсан тогтоол байгаад байгаа юм. Нөгөө ноос, ноолуурын борлуулалтын түвшнийг 1 үе шаттайгаар нэмэгдүүлье гэдэг асуудал байгаа юм. Энэ чинь нөгөө үндэсний үйлдвэрлэлээ бид нар хамгаалъя,

малчдынхаа борлуулж байгаа түүхийн эдийг нь, тэр ноос, ноолуурыг нь жилийн жилд л 100000 байх уу, 150000 байх уу л гэж айдас байгаад байдаг.

Энэ нь уг нь бид нар үндэснийхээ үйлдвэрлэлийг хөгжүүлээд 1 үе шат ахиулчих юм бол дотооддоо бид нар энэ хялгас ялгахаас дээш боловсруулалтыг нь 23 оноос хийчих юм бол дараа жилээс энэ чинь доод тал нь 200, 250 мянга хүрэх л боломж байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энийг зориглоод хийхээр ингээд Засгийн газар эргэж буцаад ингээд Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэхгүй байх юм. Энэ нөхцөл байдал одоо ямар түвшинд байгаа юм?

Б.Саранчимэг: 4 номер хариулъя. Маш тодорхой асуултууд асуусан байгаа.

Ц.Болорчулуун: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр ер нь малчид сүүлийн жилүүдэд энэ нөхцөл байдалтай холбоотойгоор зөвхөн байгалийн хадлан гэлтгүй байгалийн хадлангаар өвөл, хаврыг давахаасаа илүү таримал тэжээлийн энэ чанар чансаа ер нь энэ хэрэглээг нэлээн нэмэгдүүлчихсэн байж байгаа юм.

Тэгэхээр бид нар жилдээ газар тариалангийн эргэлтийн талбай 880 гаруй мянган га байна. Тэгэхээр бид нар нийт тариалалтыг 500 орчим мянган га-д хийж байгаа учраас бид нар цаана нь дахиад 300 гаруй мянган га-г нь ингээд өнжөөж байгаа, урини бэлтгэж өнжөөж байгаа ийм асуудал байгаа учраас ер нь ирэх жилээс бид нар аймаг орон нутагтайгаа нэлээн нягт ажиллаж тухайн орон нутагт хэдий хэмжээний таримал тэжээл хэрэгтэй байна гэдэг энэ тооцоо судалгааг гаргаж, энийгээ тариаланчидтайгаа нийлж энэ холбоосыг л яам хийж өгөх л ийм асуудал байгаад байгаа юм.

Тэгээд бид нар тэжээлээ бэлдэж өгдөг тухайлах юм бол, Дундговь аймагт шаардлагатай хэдий хэмжээний ямар найрлагатай тэжээл байна гэдгийг нь бид энэ тариалангийн бүс нутгуудаараа, аж ахуйн нэгжүүдээрээ дамжуулаад бэлтгээд өгчихдөг бол энэ бид нарын энэ өвөлжилт, хаваржилтыг давах том нөхцөл. Тэгээд зарим жил илүү тэжээл тариалалт хийгээд гайгүй өнтэй жил нь борлогдохгүй үнэ унадаг, зарим жил, өнгөрсөн жил бол тэжээл хямдхан байсан гээд тариалалт багасгачихаар энэ жил тэжээл нь хомсдоод үнэ өсчихдөг. Энэ асуудлууд иймэрхүү байдлаар зохицуулалт хийгээд явчихвал зүйтэй гэдэг байдлаар бид нар аймаг орон нутагтаа энэ захиалгат тариалалт гэдэг энэ зүйлийг л нэлээд яриад байгаа. Үүний үндсэн дээр л энэ асуудлууд шийдэгдэнэ гэж ингэж тооцоолж харж байгаа.

Хоёрдугаарт нь Монгол Улсын Засгийн газраас энэ 2022 онд бас шийдвэр гараад эрүүл бүсийг байгуулсан. Эхлээд энэ эрүүл бүс байгуулсан нь ер нь эрүүл бүс байж байж бид нар энэ их бэлчээрийн мал аж ахуйн орон, Монгол энэ нутаг дэвсгэрээр тархсан энэ 70 гаруй сая бэлчээрийн мал аж ахуй зонхилсон орны хувьд тухайн онцгойлсон бүс нутгийг эрүүл байлгаж байж махны экспортыг тогтвортой явуулах ийм нөхцөл бүрдэнэ гэдгээр Монгол Улсын Засгийн газрын шийдвэр гарч, бүс нутгийн хэмжээнд баруун 3 аймгийг, төвийн бүс нутагтаа Хөвсгөл аймгийн 6 сум, Сэлэнгэ, Булган аймгийн 1 сум гээд ингээд 7 сумыг хамарсан. Дээрээс нь энэ байгалийн барье рыг ашигласан тухайлах юм энэ 7 сумыг хамарсан Эгийн голоор явж хязгаарлагдсан ийм эрүүл бүсийг байгуулж байгаа.

Дээрээс нь зүүн аймагтаа бид нар тусгаарлагдсан аж ахуй хэлбэрээр Дорнод аймгийн Халх гол сумд 120000 га хүртэл талбайг хашаалж эндээ 120000 үхрийн аж ахуй байгуулъя гэдэг ийм шийдвэрийг гаргасан. Тэгээд энэ бааз суурийг бий болгочихвол тэнд үйлдвэрлэл

явуулж байгаа аж ахуйн нэгжүүд маань мал нь эрүүл, мал эмнэлгийн байнгын хяналт доор ингээд жилийн турш шинэ махны нийлүүлэлтийг, экспортыг хийх ийм боломж бүрдэнэ гэж харсан. Энэ ажлууд нэлээд урагштай явж байгаа. Бид нар олон улсын байгууллагууд дээр тодорхой хэмжээний эрх зүйн орчны судалгаануудыг нь хийлгэж байна. Шаардлагатай ТЭЗҮ, байгаль орчны нарийвчилсан болон ерөнхий үнэлгээнүүдийг хийлгээд ингээд ажиллаж байгаа.

Таны асууж байгаа тэр 4 махны үйлдвэрийн асуудал ерөнхийдөө бас олон жил бас яригдаж байгаа асуудал. Энэ одоохондоо нээлттэй байгаа хэдий боловч бид нар энэ 4 махны үйлдвэрийг үнийн судалгаа гаргаж үзэхэд бас тодорхой хэмжээнд үнэтэй гэсэн ийм судалгаа гарсан. КОВИД-ын нөхцөл байдлын дараа энэ үнийн өсөлттэй холбоотойгоор одоо бас үнэ нь ойролцоо очиж магадгүй байх. Тэгэхдээ ер нь тухайн үед хийж байсан тооцоо, судалгаагаар харьцангуй өндөр үнэтэй байна гэдгээрээ энэ асуудал түр зогссон байгаа.

Гурав дахь асуудал нь ноос ноолуурын энэ нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг гаргахтай холбоотой Улсын Их Хурлын тогтоол гарсан. Үүнтэй холбоотой Засгийн газрын тогтоол гараад.../минут дуусав./

Б.Саранчимэг: Дахиад нэмж 1 минут өгье.

Ц.Болорчулуун: 2022 оны 10 сар 12 сард Монгол Улсын Засгийн газраас энэ ноолуурын техникийн зохицуулалтыг баталсан. Ноолуурын техникийн зохицуулалтаараа бид зөвхөн самнасан ноолуурыг экспортод гаргах ийм боломж бүрдсэн. Үүнтэй холбоотойгоор манай ноолуурын үйлдвэрүүд маань энэ самнах технологийнхоо хүчин чадлыг нэмэгдүүлж нэлээд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтуудыг хийж, урьд нь

байсан хүчин чадлаа 2 дахин нэмэгдүүлээд ингээд ажиллаж байсан.

Үүнтэй холбоотойгоор дахиад бас энэ хугацааг тодорхой хэмжээнд хойшлуулах ийм шийдвэр гарсан учраас 24 оны 7 сарын 1 хүртэл хойшлуулахаар явж байгаад тэгээд энэ жилийн тухайд угаасан, самнасан хэлбэрээрээ, аль аль хэлбэрээрээ экспортод гарна.

24 оны 7 сарын 1-нээс хойш энэ техникийн зохицуулалт мөрдөгдөж эхлэхээр самнасан ноолуур буюу ноолуурын технологийн үе шатыг 1 түвшинээр ахиулаад гаргах ийм бололцоо нөхцөл бүрдэнэ. Энэний хооронд аж ахуйн нэгж үүдийн хөрөнгө оруул.../минут дуусав./

Б.Саранчимэг: Тэмүүлэн гишүүн тодруулъя.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр энэ тэжээл бэлтгэлийн асуудал нь үйлдвэрлэлийн асуулт дээр бид нар энэ Засгийн газрын зүгээс яамны зүгээс онцгой анхаарахгүй бол хүссэн, хүсээгүй л энэ зуд турхан жилийн жилд л болно. Тэгэхээр ерөөсөө л хамгийн том толгойны өвчин энэ болно. Тэгэхээр бид нарын хувьд ерөөсөө мал аж ахуйн салбараа цаашид авч явна гэх юм бол яг тэжээл бэлтгэлийн үйлдвэрлэлийн асуудал, энэ бэлтгэгч аж ахуйн нэгж байгууллагуудаа дэмжих энэ зах зээлийг дэмжих энэ тал дээр бодлогоор нэг ажил гаргаад хийх ёстой байх гэж хараад байгаа юм. Тэгэхээр энэ дээр 1 онцгой анхаараач.

Хоёрт саяын тэр 4 махны үйлдвэр ч гэдэг юм уу урд хөрштэй хамтарч хийх гаднын зээл тусламжаар хийх энэ асуудлууд бараг 15, 6 оноос хойш бараг 10 жилийн хугацаанд л яригдаж байгаа асуудлууд. Тэгэхээр ерөөсөө төрийн бодлого гэдэг өөрөө тогтвортой байх ёстой, тууштай байх ёстой. Урд хөрштэй ч гэдэг юм уу нэгэнтээ яриа хэлэлцээрээр тохирсон зүйл бол эргэж буцаад байх шаардлагагүй. Уг нь хиймээр л байгаад байгаа юм. Ингээд олон жил

алдсанаас болоод магадгүй бид нарын тэр алдагдсан боломж чинь өөрөө их өндөр өртөгтэй сонсогдох гээд байна. Тэгэхээр энийгээ бас та хэд үргэлжлүүлээч л гэж хэлэх гээд байгаа юм.

Б.Саранчимэг: Санал хэллээ. Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Байнгын хорооны тогтоол, шийдвэрээр энэ өнгөрсөн онд гарсан энэ хүнсний ногоотой холбоотой шийдвэрүүд. Энэ дотор энэ хүнсний ногоонд урамшуулал олгох шийдвэр ингээд явж байгаа. Тэгэхээр энэ дээр 1 зүйл хэлэхэд манай Төв аймгийн яг гол хүнсний ногоо тариалдаг самдууд дээр хүнсний ногооны урамшуулалтай холбоотой мэдээлэл чинь байхгүй байна. Авч байгаа хүн алга. Цөөхөн байна. Та хэд энэ улаан буудайн урамшуулал, хүнсний ногооны урамшуулал хоёроо яагаад энэ тайлан, мэдээлэлдээ зааглаж ч бичээгүй нийлүүлээд биччихсэн юм? Зааглаад яг хэд байгаа тоог нь хэлээд өгөөч. Тэгээд хэдхэн сум байгаа шүү дээ. Есөн-Эрдэнэ даргаа. Очоод юу хий л дээ яг ногоочдыг нь цуглуулж байгаад сургалтаа хийгээд яг нэг ийм загвар мэдээлэл гаргаад алгын чинээ 1 брошюр гаргаад өгчих л дөө. Тэд нар чинь буруу мэдээлэл яваад байна. Энэ хүнсний ногооны урамшуулал яах юм бол маш их хэмжээний татварын өр мөрөнд орно гэсэн юм хүртэл яваад байна. Энэ дээр хариулт.

Хоёрдугаар асуудал энэ Монгол төмс 2 дээр бид нар Байнгын хорооны тогтоолоор үүрэг өгсөн. Энэ ямар шатдаа явж байна? Аль хэдийн л өгсөн одоо тэгээд юу болж байна? Энэ гайгүй шүү дээ. Монгол төмс-2-ыг хэрэгжүүлбэ. Тэгэхгүй бол энэ төмсний га-гийн ургац буурсан, өвчлөл нэмэгдсэн, хэлбэр дүрс алдагдсан. Тэгээд энэ дээр гялс арга хэмжээ авахгүй бол энэ нөгөө авсан сайхан Монгол төмс-1 арга хэмжээ чинь ингээд будаа боллоо. Энэ дээр ямар ажил явагдаж байна?

Хүнсний ногооны зoorь дээр энэ 90 тэрбум төгрөг гэж байна. Энэ ерөөсөө түгээмэл ганцхан л юм байгаа. Би та хэдээс нэлээн шаардаж байгаад энэ 4 сар гараад 10 банктay гэрээ хийгээд явж байх шиг байна. Энэ дээрээ тэр зээлийн батлан даалтын сангаа сайн ашиглаж өгөөрэй. Дээрээс нь шинээр орж байгаа аж ахуйн нэгжүүд энэ арилжааны банкны шалгуур дээр чинь бүдрээд ойччихоод байгаа юм. Энэ дээр салбарын яамны зүгээс та хэд маань ямар бодлогоор дэмжих гэж байна? Тийм тэр дэмжлэгийг чинь асууя.

Үүнтэй адилхан тэр хүлэмжийн хүлэмж дээр 50 тэрбум гэж байна. Хүлэмж маш их хүлээлт үүсэж байгаа. 19 нэр төрлийн бүтээгдэхүүнээс чинь хүлэмжийн таримал нь бараг 8 нэр төрөл ч байл уу? Энэ ганцхан өвлийн хүлэмж яриад байна уу? Өвлийн хүлэмж дээр чинь дийлэх үү эс үгүй бол тэр нарлаг хүлэмж орж ирж байгаа юм уу? Энэ дээрээ нэг тодорхой хариулт өгөөдхөөч.

Төмс, хүнсний ногооны техник чинь 4 тэрбум чинь ямар үндэслэлээр тавьсан юм багадахгүй юу? Жишээлбэл төмс, хүнсний ногоо тарина гээд трактор оруулаад ир трактороор энийг би ногоо тарих гэж байгаа юм гэж хэлээд ингээд энэ урамшуулал 50 хувиа буцааж авах урамшуулалд хамрагдъя гэвэл энийгээ яаж зааглах юм бэ?

Өсөлтийн систем дээр Азийн хөгжлийн банкнаас тэр нэлээн олон сая долларын юм орж ирж байгаа юм байна. Энэ дээр тэр Борнуурын гээд одоо манай Монголын хүнсний ногооны дангаараа 1 сум тодорхой маш өндөр хувь эзэлж байгаа. Сая очсон хөөрхий сумдынх нь улсууд 1 аж ахуйн аргаар жосоохон юм хум янзалсан байна лээ. Энэ дээр энэ яам энэ төсөлтэй холбоотой асуудлыг нь тавиад бодитойгоор энэ байгаа юман дээрээ ажиллахгүй юм уу?

“Тэрбум мод” хашаажуулна гэж байна. Жимсний ногоо энэ тэрээр улсдаа

1, 2-т ордог аймгийн тариалан дээр тариалангийн газар хашаажуулах дээр энэ Төв аймгийн асуудал ороогүй байна. Энэ асуудлыг яаж явж байгаа вэ? Дарга нэгмөсөн 1 минут авчихъя цуг.

Энэ хүнсний хангамж дээр энэ цагаан идээг боловсруулах иргэдийн хүнсэнд зориулах энэ асуудал дээр тэр 1 их наядын хөтөлбөр дотор чинь ер нь тодорхой та нарын хуваарилалт дотор чинь тодорхой заасан юм байна уу? Энэ тойргоор яваад ажиллахад иргэд энэ асуудлыг маш их асуугаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр 1 тодорхой хариулт өгөөдхөөч. Та хэд бодвол энэ 1 их наядаа хуваачихсан байгаа байх. Тэгэхээр энэ дээр ямар асуудал байна?

Дэд сайдаас 1 асуулт асууя. Энэ амьд мал гарсан тоо байна. 2 он дамнаад гарч байгаа энэ бодлого дээрээ та хэд тогтвортой энэ явуулж байгаа бодлого дээрээ байх уу? Цаашид ер нь бодлого чинь ямар байна гэдэг асуулт дээр хариулт өгөөдхөөч.

Дараагийн 1 асуулт. Дахиад л хэлье. Энэ хөдөө орон нутгаар энэ үржил, селекцийн бодлого гэж юм ерөөсөө байхгүй болж байна. Дуртай дуртай малаа үржүүлж байна. Одоо бүүр сүүлдээ энэ хонь мал чинь допер, суффолк гээд л цаашаа бүүр романов энэ тэр ороод бүүр ингээд явж өглөө л дөө. Энэ дээр төлөвлөсөн, зорьсон төлөвлөлт, бодлого юм.../минут дуусав./

Б.Саранчимэг: 4 номер хариулах уу? 2 номерын микрофоныг өгье.

Д.Есөн-Эрдэнэ: Туваан гишүүний асуултад хариулъя. Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Есөн-Эрдэнэ байна. Энэ хүнсний ногооны урамшууллыг өнгөрсөн жилээс эхлээд ингээд олгодог болсон. Өнгөрсөн 8, 9 сараас эхлээд ингээд олгож байгаа. Өнгөрсөн жил нийтдээ бас 618 иргэн, аж ахуйн нэгж нийтдээ 32000 тонн хүнсний ногоонд 3.2 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон байгаа.

Тэгээд хүнсний ногооны урамшууллыг энэ жил гарал, үүслийн гэрчилгээг цахимаар олгож байгаа. Мөн урамшууллын хүсэлтийг цахимаар хүлээж авч байгаа. Урамшууллыг бас цахимаар ингээд олгож байгаа. Энэ ажлыг өнгөрсөн 6 сараас эхлээд сум орон нутгуудаар сургалтаар явж ингэж хүргэх ажлууд нэлээд хийгдэж байгаа.

Саяхан бас “Тариалангийн сэргэлт” чуулган зохион байгуулсан. Энэ хүрээнд бас төмс хүнсний ногооны эрхлэгчдэд зориулсан энэ урамшуулалд хэрхэн яаж үр өгөөжтэй хамрагдах вэ талаарх энэ сургалтуудыг хийсэн. Цаашидаа бол аймгийн зөвлөгөөнүүд ингээд явагдан. Энэ бүр дээр бас энэ сургалтуудыг хийгээд явъя гэдэг энэ брошюр мэдээлэл, иторкууд бэлдсэн байгаа. Энийг бас өргөн хүрээнд дамжуулъя гэдэгтэй бас санал нэг байна.

Монгол төмс хөтөлбөр үүнд үндсэндээ төмсний үрийн шинэчлэл хийх зайлшгүй ийм шаардлагууд зүй ёсоор байгаа. Үндсэндээ 300 мянган ширхэг бичил буцуу үйлдвэрлэж байж, жил тутам үйлдвэрлэж байж төмсний үрийн шинэчлэлийг тууштай хийх боломж байдаг юм.

Манай Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн болон Ургамал, газар тариалангийн хүрээлэн дээр энэ жилдээ 100000 тонн бичил буцуу үйлдвэрлэдэг. Цаашидаа энэ жил энэ төмсний үрийн шинэчлэл дээр онцгой анхааръя. Энэ бичил буцуу хийх лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэхээр бас улсын төсөвт 300 сая төгрөгийн төсөвт тусгаад, манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх Судалгаа хөгжлийн төв байдаг. Судалгаа хөгжлийн төв болон гарааны компанитай хамтраад энэ төмсний үрийн шинэчлэл дээр нь анхаараад ингээд ажиллаж байгаа.

Тэгээд төмсний гарсан үрийг нь бас системтэйгээр хөгжүүлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд энэ

төмсний үрийг нь бас үржүүлэхэд нь бас дэмжлэг үзүүлэхээр бас 200 сая төгрөгийн төсөв төсөвлөсөн. Энийг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд, 4 аж ахуйн нэгж Төв аймгийн Жаргалант сум, Төв аймгийн Борнуур сум, Сэлэнгэ аймгийн Хушаат сум гээд энд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид дэмжлэг өгөөд төмсний үрээ үржүүлээд явна гэсэн ийм бас хөтөлбөр, төслийг бас хэрэгжүүлээд явж байгаа гэсэн ийм мэдээлэл өгье.

Хүлэмжийн аж ахуй бас нэн шаардлагатай байгаа. Эхний ээлжид нь одоогоор бол 110 га талбайн хүлэмж байдаг. Цаашид нь Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай энэ төлөвлөгөөнд 50 гагаар хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлнэ гэсэн ийм томоохон зорилт тавьсан.

Энэ жил 50 тэрбум төгрөгийг энэ хөнгөлөлттэй зээлээр олгохоор байгуулж байгаа. Энэ дээр бол бас нарлаг хүлэмжүүд бас хамрагдаад ингээд явна. Энэ бол 4 улирлын энэ хүлэмжүүд. Тэгэхээр эд нарыг бас арилжааны банкны эх үүсвэрээр явагдана.

Мөн энэ зоорины аж ахуй байгуулахдаа бас 94 төгрөгийн хөнгөлөлттэй зээл байгаа. Эндээс 500-2500 тонны багтаамжтай 1 маягийн зураг төслийг бид бас өнгөрсөн жил боловсруулсан. Энэ зураг төслийг аймаг орон нутгуудад хүргүүлэх, энэ зураг төслийг ашиглаад бас зураг.../минут дуусав./

Б.Саранчимэг: Дахиад нэмээд хариулъя. Өөр газар тариалан дээрээ дахиж хариултаа илүү тод өгье. 2 номерын микрофоныг өгье.

Д.Есөн-Эрдэнэ: Хүлэмж ,зоорины аж ахуй дээр бас ингээд онцгой анхаараад тэгээд банкныхтай бас энэ шалгуурыг бас хэрхэн хангах вэ, газрыг бас үнэлэмжийг нэмэгдүүлэх чиглэлээр,

зоорь хүлэмжийн байгууламж өөрөө бас нөгөө үл хөдлөх хөрөнгө. Тэрийг барьцаалуулах чиглэлээр бас ингээд ажиллаж ингэж байгаа.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд бол хөдөө аж ахуйн газар тариалангийн салбарт 2 ийм арга хэмжээг хэрэгжүүлэхээр үндсэндээ төлөвлөж байгаа. Энэ дээр тариалангийн талбайг хашаажуулах, ойн зурвас байгуулах, нөгөө тал дээр агро ойн аж ахуй, жимсний аж ахуйг хөгжүүлэх гэсэн ийм чиглэлээр томоохон ийм зорилтыг дэвшүүлсэн.

Энэ жилийн тухайд санал энэ тариалангийн талбайг хашаажуулахад ойн зурвас байгуулахад нь хөрөнгө оруулалтын арга хэмжээ энд улсын төсөв дээр тусгагдаагүй, хэрэгжүүлээгүй. Энд говийн аймгууддаа бол жимсний суулгац үржүүлгийн төв байгуулахад нь илүү анхааръя гээд энэ говийн Баянхонгор, Говь-Алтайд, Дорнод, Дундговь, Дорноговь гэсэн ийм алслагдсан аймгууд дээр суулгац үржүүлгийн төв байгуулах 1.2 тэрбум төгрөгийн ийм төгрөгөөр жимс суулгагч үржүүлгийн төв байгуулж байгаа.

Борнуурын услалтын систем дээр Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариалан гээд төсөл хэрэгжиж байгаа. Энэ төслийн хүрээнд бас тодорхой хэмнэгдсэн төсөв бас байгаа. Энийг бас нарийвчилсан судалгаануудыг хийлгээд эхэлсэн. Ингээд байгаль орчны үнэлгээ хийгдээд ингээд явна.

Борнуурын услалтын систем үнэхээр Монгол Улсад бас хэрэгцээтэй нийтдээ 970 га талбай хамардаг. Энийг бас өргөжүүлээд 300 га-гаар нэмэгдүүлээд ийм зураг төслүүдийг бас дахин хийгээд энийг бүүр сэргээн засварлах ажлуудыг бас ингээд хийгдэх нь.

Төмс, хүнсний ногооны техникийн шинэчлэлтэд тийм 4 тэрбум төгрөг, төмс, хүнсний ногооны техник худалдан авсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд 50 хүртэлх хувийг нь дэмжлэг, татаас хэлбэрээр олгоё гэдэг энэ тогтоол дээр ингээд орсон тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө дээр тусгагдсан байгаа. Энийг бас энэ төслийн баримт бичгүүдээ бас боловсруулсан байгаа. Энийг бас цахимаар явуулах, энэ дээр нь шинэ техник байх ийм гол шалгуурууд тавьж байгаа.

Голцуу бас эхний ээлжид ургац хураалтын техникүүд, зүтгэгчийн трактор энэ техникүүдийг тавьж байгаа. Тэгээд цахим систем гэдэг нь цахим систем дээрээ энэ газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой эрхэлж байгаа газар тариалангийн үйлдвэрлэл, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг тогтвортой эрхэлж байгаа гэсэн энэ мэдээллүүдийг л авсан аж ахуй, дилер аж ахуйн нэгжүүдээсээ техник авсан тохиолдолд нь 50 хүртэл хувийн дэмжлэг үзүүлье гэсэн ийм төсөл хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа.

Б.Саранчимэг: 3 номер нэмж хариулья.

М.Ганхүлэг: Туваан гишүүний асуултад хариулья. 2022 онд үндсэндээ Замын-Үүд боомтоор мал махны эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх зорилгоор бас амьд малыг экспортод гаргах энэ ажлууд бас хийгдсэн. Нийтдээ 28503 толгой малыг бас экспортод гаргасан.

2023 оны эхний улирлын 3 сарын байдлаар 24540 толгой малыг бас амьдаар гаргасан байгаа. Яг бодлогын хувьд түр хугацаанд энэ арга хэмжээг бас авч хэрэгжүүлэн ажиллаж байгаа. Хэд хэдэн шалтгаанууд бас байгааг та бүхэн маань бас бүгдээрээ мэдэж байгаа болов уу гэж бодож байна. Бэлчээрийн энэ даацтай холбогдолтой. Сүүлийн жилүүдэд малын тоо толгой бас өсөж,

71.1 сая тоо толгой малыг бид бүхэн бас тоолуулсан. Тэгээд бид бүхэнд нөөц бололцоо бас юмнууд бас байна.

Цаашидаа боловсруулах илүү нэмүү өртөг шингээсэн ийм бас үйлдвэрлэлүүдийг дэмжих, малын гаралтай түүхий эдийг бас экспортод гаргах энэ чиглэлийн ажлууд дээр голчлон анхаарч анхаарал хандуулж бас ажиллахаар Хүнс, хөдөө аж ахуйн яамны зүгээс ажиллаж байна. Богино хугацаанд энэ арга хэмжээг бас авч хэрэгжүүлж байгаа гэдгийг бас танд бас хэлье.

Махны экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр мөн бас нэмэлтээр хийж байгаа ажил бол 1 цэгийн цонхны системийг бас бий болгож байгаа. Энэ нь одоо зөвшөөрөл олгох энэ бас ажиллагааг богино хугацаанд бас цахимаар хийх ийм боломжтой болгож байгаа. Төрийн 6-7 байгууллагатай харилцаж махаа бас экспортод гаргаж байгаа энэ явдал цахим бас болж байгаа. Тэгээд энэ зөвшөөрөл олгох энэ цахим систем бас бий болж байгаа гэдгийг бас хэлье.

Хоёрт Дархан арьс ширний цогцолбортой холбогдолтой ажлын хэсэг байгуулагдаад ажлууд бас явж байгаа. Хөгжлийн банкин дээрх хувийн хэвшлийн бас 180 га дээрх бүтээн байгуулалтын 5 дэд бүтцийн ажил байгаа. Энэхүү 5 дэд бүтцийн ажлыг хүлээж авах энэ ажлуудын хэлтсүүд бас хийгдээд энэ ажлын хэсгийг бас миний бие ахлан ажиллаж байгаа.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Эрчим хүчний яамны 3 сайдын тушаалаар яг энэ газар дээр нь очиж энэ 5 дэд бүтцийн өнөөгийн бас энэ гүйцэтгэлийг дүгнэх ажлын хэсэг очиж ажилласан. Барилга хөгжлийн төв, Эрчим хүчний төвийн дүгнэлтүүд бий болоод ингээд хэлцэл хийх тодорхой дүнтэй болж аваад үндсэндээ хувийн хэвшилтэйгээ бас хэлцэл хийх энэ шатдаа ороод явж байна. Ингэснээрээ

энэ хийгдсэн байгаа 5 дэд бүтцийг ишилжүүлэн авах энэ ажлууд Засгийн газарт бас ойрын хугацаандаа танилцуулагдаад маргаантай энэ асуудлууд бас ингээд ишийдэгдэх тодорхой ийм үр дүнгүүд бас гарсан байгаа гэдгийг хэлье.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр өнөөдөр бас энэ газар тариалангийн салбарт мөн хүнс, хөдөө аж ахуйн салбарт тулгамдаж байгаа асуудлын талаар мэдээлэл хийлээ.

Тэгэхээр мэдээлэлтэй холбогдуулж бас цөөхөн асуулт асууя гэж бодож байна. Эрүүл хүнс, хүнсний хангамж гээд Монгол Улсын Ерөнхийлөгч санаачлаад энэ дээр Улсын Их Хурал дээр 36 дугаар тогтоолыг баталсан байгаа. Тэгэхээр энэний дагуу холбогдох тодорхой хуулиудыг та бүгд яаралтай бас оруулж ирэх хэрэгтэй. Энийгээ оруулж ирэхийнхээ өмнө бас саналуудаа мэргэжлийн хүмүүсээс илүү их сайн асууж, бодит ийм хуулийн төслөө оруулж ирэхийг хүсэж байна.

Ер нь бас энэ дээр удаашралтай байгаа гэдгийг онцолж хэсэг хэлэхийг хүсэж байна. Цаашидаа бид нар мэдээж энэ эрүүл хүнс, хүнсний хувьсгалыг бид нар хийгээд ярих биш бодит ажлуудыг болгох зайлиггүй шаардлагатай байгаа. Тэгэхдээ иргэдтэй уулзаад явж байхад харин ч бас өчигдөр гэхэд хүнсний холбооныхонтой уулзахад маш хурдтай ажиллаад байна. Харин өмнө нь ингээж газартаа буухгүй байсан гэдэг юмыг хэлж байх шиг байна.

Ер нь одоо бид нар энэ баялаг бүтээгчидтэйгээ уулзаад явж байхад тэд нартай хэлэлцүүлэг хийхэд энэ төрөөс өгч байгаа дэмжлэг энэ арилжааны 10 банктэй энэ Хөдөө аж ахуйн яам чинь санамж бичигт гарын үсгээ зурчихлаа, гэрээ хийчихлээ, энэ яг эзэндээ зөв хүрээсэй гэж байгаа.

Тийм учраас энэ дээр их сайн мэдээллээ өгөх хэрэгтэй байна. Жишээ нь

сая ингээд говьд 4 жил Дундговьд гэхэд 1 гэр бүлийн хос 4 жил тэр 6 модыг арчилсаар байгаад 4 жилээсээ нөгөө алимаа өгөөд органик алим болчихсон зуун хэдэн кил алимыг авчихсан байх жишээтэй. Тэгээд тэд нар болохоор ерөөсөө энэ төрийн бодлогын мэдээлэл байдаггүй гээд байгаа юм.

Тэгэхээр та бүгд маань яг бас 1 зөв хүмүүстээ, хийж байгаа хүмүүст нь энэ 1 мэдээллээ хүргэх тал дээр илүү их анхаарч ажиллаасай гэж бодож байна.

Нөгөө талаар хүн эрүүл байхын тулд хөрс эрүүл байж хөрсөнд ургасан тэр хүнс маань эрүүл байх ёстой. Тийм учраас энэ хүнсний аюулгүй байдалтай холбоотойгоор энэ газар тариалан, тэр дундаа энэ жимс хүнсний ногоо тариалахад ашиглагддаг химийн бордоо мөн малын эм тариа антибиотикийн замбараагүй энэ хэрэгцээнд тавих хяналт, зохих норм хэмжээг бас анхаарах хэрэгтэй байгаа. Энэ дээр бас хяналт шалгалт хийсэн дүн байна уу?

Нөгөө талаар одоо органик бүсийг тусдаа бас органик бүс бий болгоно гээд яригдаад энэ маань бас ажил бас болоогүй байна. Энийгээ хурдан ажил болгооч. Тэгэхгүй бол эрүүл бүсийг байгуулна гээд яриад байдаг. Өнөөдөр энэ бүсээ зөвхөн тэр 7 аймаг биш бас бусад аймгийн зарим сумыг ч гэсэн ийм органик сум болгох тал дээр илүү их анхаарч ажиллаач гэж хүсэж байна.

Тэгэхээр энэ антибиотик тарьчихсан л бол органик биш болчихдог юм байна. Тэгэхээр энэ дээрх хяналтыг тодорхой хариулж өгөөч.

Нөгөө талаар энэ газар тариалангийн салбарт төрөөс олгож байгаа энэ хөнгөлөлттэй зээл, үзүүлж байгаа дэмжлэг, худалдан авалтад энэ дотоодын үйлдвэрлэгчдээ дэмжих, бордоо, түүхий эд авах мөн тийм нөхцөл шаардлага тавигдаж байгаа юу? Энэ дээр 1 асуулт асууя.

Нөгөө талаар бол үрийн талаар их тодорхой мэдээлэл өгсөн байна л даа. Тэгэхээр бид нар энэ Канадын Рижина муж Канад улсынхаа 80 хувийг үрээр хангадаг байх жишээтэй. Тэгэхээр эндээс бид нар тэр үрийг авах бүрэн боломжтой юм байна лээ. Ганцхан Беларусь энэ ойр хавиасаа авдаг биш энэ үрийнхээ чанарыг сайжруулахын тулд зайлиггүй бас ингэж өөрчлөх хэрэгтэй байгаа энэ цаг үед энэ Канадын Рижина мужтай манайхан бас их туршилага судалж явдаг. Энэний туршилагыг бас авч, судалж хэрэглэж байгаа зүйл байгаа юу гэсэн 1 ийм асуулт байна.

Нөгөө талаар тэр махны 4 үйлдвэрийг нэгэнт 2 төрийн хооронд ингээд яригдчихсан байгаа ажлыг одоо бид нар өнөөдөр үнэ ярих биш. Энийг ажил болгох дээр одоо Хөдөө аж ахуйн яам анхаарч ажиллаач гэдэг 1 хүсэлт байна. Баярлалаа.

4 номер хариулъя.

Ц.Болорчулуун: Саранчимэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр хуулиуд дээр бас онцгой анхаарч байгаа. Тухайлах юм бол “Хүнсний хангамжийн аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолд 8 хуульд өөрчлөлт оруулахаар тусгагдсан байгаа.

Дээрээс нь ер нь энэ 5 жилийн үндсэн чиглэлд манай салбарт нийтдээ давхардсан тоогоор 20 хуулийг бид шинээр боловсруулах буюу шинэчлэн найруулж нэмэлт, өөрчлөлт оруулахаар ингээд тусгагдсан. Бид эхний ээлжид энэ мал аж ахуйн салбарын хуулиудаа 1 багц хууль болгоод 6 хуулийг нэгтгээд боловсруулаад одоо удахгүй Засгийн газарт өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын чуулганд өргөн мэдүүлэхээр ингээд ажиллаж байна. Яамуудаас саналаа аваад.

Бусад энэ газар тариалантай холбоотой тухайлах юм бол. Тариалангийн даатгалын тухай хууль,

Хүнсний, ургамлын эрүүл мэнд, Ургамал хамгааллын тухай хууль гээд энэ хуулиуд дээрээ ер нь бид нар төлөвлөсөн хуулиуд дээрээ бүгдэд нь зохих түвшинд нь ажлуудаа эхлүүлчихсэн явж байгаа. Одоо эцсийн энэ хууль мэдээж боловсруулж батлуулна гэдэг тодорхой хэмжээний цаг хугацаа, тооцоо судалгаа шаардлагатай учраас энэ үе шатынх нь тооцоо судалгаанууд дээр ажиллаж байгаа гэдгийг бас хэлье. Таны хэлсэнчлэн энэ хуулиудын хугацаа удааширалтай байгаа дээр анхаарч ойрын хугацаанд энийг өргөн барьж мэдүүлэх энэ ажлаа шуурхайлж ажиллана.

Эрүүл бүс байгуулах ажлыг Монгол Улсын Засгийн газрын шийдвэр гараад энэ 4 байришд ингээд тогтоочихсон. Тэгэхээр бид нар эхний ээлжид энэ эрүүл бүсээ бас жишиг болгоод ингээд гаргаад ирье. Энэ нэг талаасаа эрүүл бүс гээд бүс нутгийн хувьд тогтоочихсон нөгөө талдаа бас тусгаарлагдсан аж ахуйн хэлбэрээр бас тогтоочихсон учраас энийг бид нар 1, 1 жишигийг гаргаадахъя. Тэгээд энийгээ цаашаа жишиг болчихвол энийгээ амжилттай хэрэгжүүлчихвэл бусад аймаг сумын нутгууд дээр ингээд жишиг болгоод ингээд цаашаа явуулах, нэмэгдүүлэх ийм бололцоотой гэж харж байгаа.

Бордооны үйлдвэрийн тухайд гэх юм бол бас Монгол Улсын төсвийн тухай хуулийг дагаж хүнс, хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрүүдийн тоног төхөөрөмжүүдийг гаалийн албан татвараас чөлөөлөх иймд хууль гарсан. Үүнтэй холбоотойгоор Монгол улсын Засгийн газраас энэ үйлдвэрүүдийн тоног төхөөрөмжийн жагсаалтыг саяхан баталсан байгаа. Энэ дээр бордооны үйлдвэрийг гаалийн албан татвараас чөлөөлөх ийм зохицуулалт орсон. Мэдээж дотоодын бордооны үйлдвэрийг дэмжих чиглэлд энэ 36 дугаар тогтоолын хүрээнд бордооны үйлдвэрүүдэд олгох тодорхой хэмжээний хөнгөлөлттэй зээл олгох гээд энэ энэ олон арга хэмжээнүүд явж байгаа.

Тэгээд манай дотоодын үйлдвэрлэл явуулж байгаа бас 10 гаруй жижиг бордооны үйлдвэрүүд байгаа. Эдгээр үйлдвэрүүд хүчин чадлаа нэмэгдүүлэх, шинээр орж ирж байгаа үйлдвэрүүд нь шинээр хүчин нэмэгдүүлэх ийм бололцоо нөхцөл байна гэж ингэж харж байгаа.

Энэ Канад улсын энэ үр тарианы үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч орнуудын нэг. Тэгэхээрээ манай Дарханы ургамал газар тариалангийн хүрээлэн бол энэ Канадын Режина мужтай бас тодорхой тодорхой хэмжээний хамтын ажиллагаатай байгаа. Тэгэхээр энэ Канад улсад ургадаг үр тарианы болон төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийн янз бүрийн үр сортыг Монгол оронд нутагшуулах тал дээр тодорхой ажлууд хийж байгаа. Дээж оруулж ирж бид нар бас туршиж үзэж байгаа. Тэгээд энэ туршилтын дүн амжилттай болоод Монгол оронд нутагших сортоор батлагдах ийм тооцоо судалгаа гарах юм бол энэ сортын зөвлөлөөрөө оруулаад, хэлэлцүүлээд, батлуулаад ингээд хамтын ажиллагааг өрнүүлээд явах ийм бололцоотой.

Тэгээд Канадын энэ энэ Саскачеван мужид байдаг Режина, Саскачеван хотод жил болгоны хавар том үзэсгэлэн зохион байгуулагддаг. Манай тариаланчдын төлөөлөл бас хэд хэдэн удаа энэ арга хэмжээнд оролцож байсан.

Тэгэхээр энэ Ургамал, газар тариалангийн хүрээлэн дээр энэ ажлууд явж байгаа. Энэ туршилтын үр дүнд гараад ирвэл бид нар сортын зөвлөлөөр батлуулаад энэ Канадын бас чанар сайтай, ганд тэсвэртэй бүс нутгийн үед манайд тохирох ийм сортууд дээр хамтарч ажиллах ийм бололцоо байна гэж ингэж харж байгаа.

Б.Саранчимэг: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Гишүүд үг хэлж дууслаа.

Тэгэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Өнөөдрийн хуралд оролцсон ажлын хэсгийнхэн яамныханд баярлалаа.

13.13 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР